

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

1992-01-13

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Арван зургадугаар зүйл

Монгол улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

8/соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Далдугаар зүйл

2. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

Мэдэгтүн, сахигтун

2. Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.

Мэдэгтүн, сахигтун!

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ

1998-08-28

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

2 дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.

3 дугаар зүйл.Мэдээлэлд хяналт тавихыг хориглох

3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зөлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ.

Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.

3.2.Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бүгүүд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

4 дүгээр зүйл.Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох

Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ

1994-11-01

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

7 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах

1.Иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд,ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг няцаалгах, ийнхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг арилгуулах, гэрлэгч өөрийн эрх, ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзвэл түүнээс учирсан эд хөрөнгийн бус гэм хорыг арилгуулахыг тус тус шаардах эрхтэй.

2.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг, гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн этгээд буруугүй болохоо нотолж чадахгүй бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

3.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас болон гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөнөөс учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх тодорхойлно.

/Энэ зүйлд 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

II хэсэг ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙ

86 дугаар зүйл.Оюуны үнэт зүйл

1.Оюуны үнэт зүйлд нээлт, шинэ бүтээл, оновчтой санал, зохиогчийн эрхэд хамаарах бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг хамаарна.

5.Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлд:

1/шинжлэх ухаан, уран зохиолын зэрэг утга зохиолын аман буюу бичмэл бүх төрлийн бүтээл;

11/дуу, авиа, дүрс бичлэгийн бүтээл;

13/зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааг илэрхийлж чадахуйц бусад бүтээл.

88 дугаар зүйл. Өмчлөгч биш этгээдийн эрх

1.Өмчлөгч биш этгээд нь эд хөрөнгө, оюуны үнэт зүйл,эрхийг хууль буюу гэрээгээр тодорхойлсон өмчлөгчөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

2.Хуульд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйлийг гагцхүү өмчлөгчийн буюу эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр бусад этгээд ашиглана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ӨМЧЛӨХ ЭРХ ҮҮСЭХ, ДУУСГАВАР БОЛОХ

136 дугаар зүйл.Оюуны үнэт зүйл өмчлөх эрх үүсэх

1.Хуульд өөрөөр заагаагүй бол оюуны үнэт зүйл бүтээсэн этгээдийн өмчлөх эрх нь уг зүйлийг бүтээсэн үеэс үүснэ.

2.Өмчлөгч нь оюуны үнэт зүйл бүтээснээ тухайн үед нь баталгаажуулах үүрэгтэй. Ийнхүү баталгаажуулсан нь зайлшгүй шаардлагатай үед уг зүйлийг бүтээснээ нотлох үүргээс өмчлөгчийг чөлөөлөхгүй.

3.Оюуны үнэт зүйлийн өмчлөгч болохыг хуульд заасан журмын дагуу бүртгэсэн бүртгэлээр тодорхойлно.

Гэм хор учруулснаас үүсэх үүрэг

V ХЭСЭГ

ГЭРЭЭНИЙ БУС ҮҮРЭГ

ДӨЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ

Гэм хор учруулснаас үүсэх үүрэг

377 дугаар зүйл.Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

1.Бусдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг хохироосон эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.

/Энэ хэсэгт 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/

2.Гэм хор учруулсан этгээд ийнхүү гэм хор учруулсан нь түүний буруугаас болоогүй гэдгийг нотолбол хуульд зааснаас бусад тохиолдолд ийнхүү гэм хор учруулсны хариуцлагыг хүлээхгүй.

3.Эрх үүргийнхээ ёсоор бусдад гэм хор учруулсан этгээд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд уг гэм хорын хариуцлагаас чөлөөлөгдөнө.

6.Хууль ёсны үйлдлийн улмаас учруулсан гэм хорыг хуульд тусгайлан заасан бол арилгуулж болно.

7.Гэм хорын хэмжээг гагцхүү шүүх тогтооно.

392 дугаар зүйл.Эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах

1.Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эд

хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

2.Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга, хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзан, нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох ба мэдээ тараасан уг хэлбэрээр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.

4.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэм хорыг арилгах хэмжээг үйлдлийн шинж чанар, нөхцөл байдал, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзан Захиргааны хариуцлагын тухай болон Эрүүгийн хуульд заасан торгуулийн хэмжээнд багтаан мөнгөөр тооцож тогтооно.

/Энэ хэсгийг 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ

1992-05-08

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Цэцийн чиг үүрэг, эрх хэмжээ

8 дугаар зүйл. Үндсэн хуулийн биелэлтэд тавих дээд хяналт

1.Цэц Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ энэ зүйлд заасан маргааны талаар дүгнэлт гаргах, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргааныг магадлан шийдвэрлэх замаар хэрэгжүүлнэ.

2.Цэц Үндсэн хуулийг зөрчсөн тухай дараахь маргааныг хянан үзэж, дүгнэлт гарган Улсын Их Хуралд оруулах бөгөөд хэрэв дүгнэлтийг нь Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Цэц ийнхүү хүлээн зөвшөөрөхгүй болсон үндэслэлүүдийг дахин хянан үзэж Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан эцсийн шийдвэр гаргана.

1/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх:

2/ зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх:

3/ Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх:

4/ Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх:

5/ ард нийтийн санал асуулгын талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх:

6/ Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх:

4.Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын олон гэрээ, сонгуулийн төв байгууллагын шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр бүхлээрээ буюу тэдгээрийн зөрчилтэй зүйл, хэсэг, заалт хүчингүй болно.

5.Цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад

23 дугаар зүйл. Цэцийн үйл ажиллагааг саатуулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

3.Цэцийн хууль ёсны үйл ажиллагааг саатуулах, дарамт үзүүлэх зорилгоор гүтгэсэн, доромжилсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал шүүх түүнийг 5000-50000 төгрөгөөр торгоно./ Энэ хэсгийг 1995 оны 4 дүгээр 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. /

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАРААНЫ ТЭМДЭГ, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРИЙН ТУХАЙ

1996-12-19

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ " Барааны тэмдэг " гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд, иргэн өөрийн бараа, үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор хэрэглэх тодорхой агуулга бүхий үсэг, тоо, дүрс буюу эдгээрийг хосолсон дүрсэн илэрхийллийг

4/ " Аж ахуйн нэгжийн нэр " гэж зохих журмын дагуу байгуулагдсан хуулийн этгээд өөрийн үйл ажиллагаа явуулахад ашиглах оноосон нэрийг

4 дүгээр зүйл. Барааны тэмдгээр бүртгүүлэх зүйл, түүнд тавих шаардлага

1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасан шаардлага хангасан тэмдгийг барааны тэмдгээр бүртгэнэ.

2. Дараахь зүйлийг барааны тэмдэгт тооцохгүй:

1/ юмс, үзэгдлийг бодитой оршин байгаа байдлаар нь

илэрхийлсэн үг, дүрс

2/ нийтэд дэлгэрсэн нэр томъёо, дүрс, геометрийн жирийн дүрс, тоон

илэрхийлэл, үл ялгагдах үсэг, тэмдэгт

3/ барааны үндсэн нэр, барааны тоо, хэмжээ, жин, чанар, зориулалт, үнэ,

үйлдвэрлэсэн газрын нэр, арга, хугацаа зэргийг тайлбарласан үг, дүрс

4/ төөрөгдөлд оруулж болзошгүй буюу худал зүйл

5/ газар зүйн нэр, түүний товчилсон үсэг, газрын зургийг заасан, байрладаг газрыг заасан тэмдгээс бүрдсэн

6/үл ялгагдах хэлбэрээр илэрхийлэгдсэн хүний нэр

7/ үл ялгагдах ердийн газрыг энгийн аргаар илэрхийлсэн

5 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн нэр, түүнийг бүртгэхэд тавих шаардлага

Аж ахуйн нэгж нь өөрийн оноосон нэртэй байх ба түүнээ ашиглах онцгой эрх эдэлнэ.

2.Аж ахуйн нэгжийн нэр нь тухайн нэрийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгосноор хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл. Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг бүртгэх, гэрчилгээ олгох

1.Оюуны өмчийн газар барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг бүртгэх шийдвэр гаргавал уг тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг улсын бүртгэлд бүртгэж, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн гэрчилгээ олгон, мэдүүлгийг нь барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн санд хадгална. Оюуны өмчийн газар бүртгэсэн барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн мэдүүлгийг гэрчилгээний хүчинтэй байх хугацаа нь дууссанаас хойш 10 жилийн хугацаанд хадгална.

11 дүгээр зүйл. Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа, түүнийг сунгах

1.Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн гэрчилгээ нь түүнийг олгосон огнооноос эхлэн 10 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг эзэмшигчийн өргөдлийг үндэслэн тухай бүр 10 жилээр сунгаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

Бусад зүйл

23 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1997 оны 02 дугаар сарын 01- ний өдрөөс хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

1986-12-05

ТУСГАЙ АНГИ

ТӨРИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

67 дугаар зүйл Дайныг сурталчлах

Дайныг ямар нэгэн хэлбэрээр сурталчилсан бол хоёроос найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ зүйлд 1993 оны 6-дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

71 дүгээр зүйл.Төрийн нууц задруулах

1.Улсын нууцад хамаарах объект, тодорхой үйл ажиллагаа,мэдээ, бэримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцдаг, эсхүл ажил албаны үүргийн дагуу мэдсэн этгээд тэдгээрийн нууцыг задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Албан үүргийн хувьд төрийн нууцыг мэдэх ёсгүй этгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг олж авах зорилгоор хайсан, бусдад задруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Төрийн нууцыг задруулсны улмаас хүнд хор уршиг учирсан бол гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ зүйлийг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан

ХОЁРДУГААР БҮРЭГ

ХҮНИЙ АМЬ БИЕ, ЭРҮҮЛ МЭНД, ЭРХЧӨЛӨӨ, НЭР АЛДРЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

117 дугаар зүйл.Гүтгэх

1.Бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан илт худал гүжирдлэг тараасан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, арван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 1993 оны 2 дугаар сарын 15,1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Гүтгэлгийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшруулан тараасан, эсхүл нэргүй захидлаар ирүүлсэн буюу гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэнбол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 1993 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3.Хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэсэн бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

118 дугаар зүйл.Доромжлох

1.Бусдын нэр төр, алдар хүндийг амаар, бичгээр буюу бусад хэлбэрээр зориуд доромжилсон бол зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, арван мянган хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 1993 оны 2 дугаар сарын 15, 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Энэ хэргийг доромжлох гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн буюу хэвлэлд нийтлүүлэх замаар бусдыг доромжилсон бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин мянгаас наян мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 1993 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

ҮҮ БҮЛЭГ
ХҮНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОН БУСАД ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

146 дугаар зүйл.Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих

Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу арван мянгаас жаран мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

146. 1 дүгээр зүйл.Иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг задруулах

Мэргэжлийн болон албан үүргээ гүйцэтгэх явцад иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг итгэмжлэгдэн мэдсэн этгээд түүнийг задруулж ноцтой хор уршигт хүргэсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин мянгаас наян мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Ү БҮЛЭГ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

1752 дугаар зүйл.Хориглосон зар сурталчилгаа эрхлэх

Донорын буюу өөрийн цус, эд, эрхтэнг худалдах, худалдан борлуулахаар сурталчилсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу зуун мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгоно.

/Энэ зүйлийг 2000 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн/.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ
ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

204 дүгээр зүйл.Зориуд худал мэдээлэх

1. Гэмт хэрэг үйлдэгдсэн гэж зориуд худал мэдээлсэн бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг хийхдээ бусдыг хүнд гэмт хэрэгт холбогдуулсан буюу яллах нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл шунахай зорилго агуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

209 дүгээр зүйл. Урьдчилсан мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн мэдээ баримтыг задруулах

Урьдчилсан мөрдөн байцаалт, хэрэг бүртгэлтийн мэдээ баримтыг прокурор, мөрдөн байцаагч болон хэрэг бүртгэж байгаа этгээдийн зөвшөөрөлгүй задруулсан бол зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу арван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ
/Энэ зүйлийг 2000 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн/.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ, ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

256 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнд садар самууны зүйлсийг тараах

1. Садар самууны хэвлэл, кино, дүрс бичлэг, болон тэдгээртэй адилтгах бусад зүйлийг насанд хүрээгүй хүнд худалдсан, сурталчилсан, өөр хэлбэрээр тараасан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Садар самууны зүйлийг бэлтгэх буюу тараахад насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу хоёр зуун мянгаас дөрвөн зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үйлдлийг насанд хүрээгүй хүмүүст хүч хэрэглэх, эсхүл садар самууны зүйлийг тараах гэмт хэрэгт урьд ял шийтгэгдсэн этгээд, эсхүл зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдсэн бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

/Энэ зүйлд 1993 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон ба уг зүйлийг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/.

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ

1963-12-24

13 дугаар зүйл. Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хамгаалах

Иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

19 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний

нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна. Хэрэв шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсоно.

/Энэ зүйлийг 1994 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/.

113 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл

Эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл:

З/хэвлэлд нийтлэгдсэн мэдээлэл;

ХОРИНДОЛДУГААР БҮЛЭГ

ТАСЛАН ШИЙДВЭРЛЭХ ТОГТООЛ ГАРГАХ

294 дүгээр зүйл. Шүүгчдийн зөвлөлгөөний нууц

Шүүх таслан шийдвэрлэх тогтоолыг зөвлөлдөх тасалгаанд үйлдэнэ. Шүүгчид зөвлөлдөж байгаа үед зөвлөлдөх тасалгаанд уг хэргийг хэлэлцсэн шүүх бүрэлдэхүүнээс өөр хүмүүс байж болохгүй. Шүүгчид зөвлөх үед хэлэлцсэн зүйлийг задруулж болохгүй. Шүүгч зөвлөх үед хэлэлцсэн зүйлийг задруулж болохгүй

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ, ПРОКУРОР, МӨРДӨН БАЙЦААХ, ХЭРЭГ БҮРТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ ЗӨРЧСӨН АЖИЛЛАГААНЫ УЛМААС ИРГЭНД УЧИРСАН ХОХИРЛЫГ АРИЛГАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

1990-03-23

ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭНД УЧИРСАН ХОХИРЛЫН ТӨРӨЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

12 дугаар зүйл. Хууль зөрчсөн ажиллагааны тухай мэдээлэл

. Иргэнийг ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан таслан сэргийлэх арга хэмжээ болгож цагдан хорьсон, эсхүл захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ авсан тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа дурдсан ажиллагаа хууль зөрчсөн болох нь нотлогдвол шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллага уг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан 10 хоногийн дотор холбогдох мэдээлэл хийж залруулах үүрэгтэй.

15 дугаар зүйл. Хохирол арилгуулах тухай өргөдлийг хянан шийдвэрлэх

Шүүх хуралд хөдөлмөрийн хамт олон, олон нийтийн болон хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчдийг оролцуулж болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНДСЭН ЭРХ, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ

1991-06-24

6 дугаар зүйл.Бүтээгдэхүүний талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл авах

4.Хэрэглээнд гаргасан бүтээгдэхүүн хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулж болох нь нотлогдвол энэ тухай үйлдвэрлэгч, худалдагч олон нийтэд нэн даруй мэдээлэх үүрэгтэй.
Мөн энэ тухай орон нутгийн Хурлын гүйцэтгэх захиргаа, улсын хяналтын холбогдох байгууллага хэвлэл, мэдээллийн болон бусад арга хэрэгслээр олон нийтийн сонорт хүргэх арга хэмжээ авна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

НАМЫН ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗВЭЛ ЗОХИХ АЛБАН ТУШААЛЫН ТУХАЙ

1991-08-28

1 дүгээр зүйл.Төрийн дор дурдсан албан тушаалд сонгууль болон томилолтоор ажиллаж байгаа улс төрийн аль нэгэн намын гишүүн, Монгол Улсын иргэн уг албан тушаалд байх хугацаандаа намын гишүүнээс түдгэлзэнэ:

7/төрийн хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах болон хэвлэл мэдээллийн ажилтан;

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ХУУЛЬ

1992-04-04

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

5 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

Сонгуулийн ерөнхий хороо уг тайланг хянан үзэж, сонгууль дууссан өдрөөс хойш гурван сарын дотор дүнг төрийн төв хэвлэлд нийтэлнэ.

\Энэ зүйлийн торгуулийн хэмжээг 1996 оны 1 сарын 16-ны өдрийн хуулиар өөрчилсөн\

6 дугаар зүйл.Сонгуулийн эрхийг хангах хууль зүйн баталгаа

8.Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн заалтыг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагыг шүүх 250,0 мянга хүртэл төгрөгөөр торгоно.

\Энэ зүйлийн торгуулийн хэмжээг 1996 оны 1 сарын 16-ны өдрийн хуулиар өөрчилсөн\

ТАВДУГААР БҮЛЭГ НАМ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ, СОНГУУЛИЙН ӨМНӨХ УХУУЛГА, СУРТАЛЧИЛГАА

21 дүгээр зүйл.Сонгуулийн өмнөх ухуулга,сурталчилгаа

3.Монгол Улсын радио, телевизээр нам, эвсэл, нэр дэвшигчдэд сонгуулийн ухуулга, сурталчилгаа, үнэ төлбөргүй явуулах хугацаа, боломж нь нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөгч бие даасан нэр дэвшигчдэд харилцан адил байна.

4. Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоож олгосон хугацаанаас бусад цагт нам, эвсэл, нэр дэвшигч улсын радио, телевизээр сурталчилгаа явуулбал үнэ хөлсийг төлнө. /Энэ хэсэгт 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.

5. Улс төрийн намуудын харьяалалд байгаагаас бусад өмчийн аль ч хэлбэрийн радио, телевиз, сонин, сэтгүүлээр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар дагнасан сурталчилгаа явуулахыг хориглоно.

/Энэ хэсгийг 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ

30 дугаар зүйл. Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нам, эвслийн нэр дэвшигчнам, эвслийнхээ, бие даан нэр дэвшигч өөрийн хөтөлбөрийг тайлбарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга, сурталчилгаа хийх, сонгуулийн тойргийнхоо холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

3. Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

НАЙМДУГААР БҮЛЭГ САНАЛ АВАЛТ БОЛОН СОНГУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ, ДАХИН САНАЛ АВАХ, СОНГУУЛЬ ЯВУУЛАХ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙГ НӨХӨН СОНГОГДСОНД ТООЦОХ

40 дүгээр зүйл. Сонгуулийн хэсэгт санал авалтыг хүчингүйд тооцох, дахин санал авах

3. Дахин санал авах ажлыг дуустал ухуулга сурталчилгаа хийхийг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ

1992-05-13

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар зүйл. Улсын аюулгүй байдлыг хангах үндсэн зарчим

Улсын аюулгүй байдлыг хангахад хуулийг дээдлэх, үндэсний ашиг сонирхол, эв нэгдлийг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, төрийн нууцыг чандлан хамгаалах үндсэн зарчмыг баримтална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДЛААР БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8 дугаар зүйл. Үйлдвэр, албан газар, байгууллагын үйл ажиллагаа

1.Үйлдвэр, албан газар, байгууллага улсын аюулгүй байдлыг хангах асуудлаар дараахь үүрэгтэй:

З/тус тусын мэдэлд байгаа хуулиар тогтоосон төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хамгаалж, энэ асуудлаар тогтоосон журмыг сахиж биелүүлэх;

9 дүгээр зүйл.Иргэний үйл ажиллагаа

1.Монгол Улсын иргэн улсын аюулгүй байдлыг хангах асуудлаар дараахь үүрэгтэй: 1/хуулиар тогтоосон төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ

1992-05-29

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН БҮТЭЦ

10 дугаар зүйл.Зөвлөлийг мэдээллээр хангах тогтолцоо

3.Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээллийн нэгдсэн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалтад байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ

1992-11-27

ХОЁРДУГААР ЗҮЙЛ ЗАХИРГААНЫ ЗАРИМ ЗӨРЧИЛ ҮҮНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИЦЛАГА

302 дугаар зүйл.Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, цагдаагийн байгууллагад худал мэдээлэл өгөх

2.Гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих, гэмт хэрэгтнийг мөрдөн хөөх, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учирч болох гэмтэлтэй хүмүүсийг эмнэлэгт, гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх, гэмт хэрэгтнийг баривчлах, гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тухай яаралтай мэдээллийг цагдаагийн байгууллагад дамжуулахад тээвэр, холбоо, мэдээллийн хэрэгслээ цагдаагийн эрх бүхий ажилтанд ашиглуулахаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан бол 500-5000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

/Энэ хэсгийн торгуулийн хэмжээг 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

303 дугаар зүйл.Хорих байгууллагын ажилтны хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх

2.Оргосон хоригдлыг мөрдөн хөөх, баривчлах үед тээвэр, холбоо, мэдээллийн хэрэгслээ хорих байгууллагын эрх бүхий ажилтанд ашиглуулахаас хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзсан бол 500-5000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

342 дугаар зүйл.Компьютер, мэдээллийн сүлжээг ашиглах журам зөрчих, компьютер, мэдээллийн сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх

Компьютер, мэдээллийн сүлжээг ашиглах журам зөрчсөн, компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтэрсний улмаас мэдээллийг болгоомжгүйгээр өөрчлөх, устгах, хаахад хүргэсэн буюу компьютер, түүний төхөөрөмжийг ашиглах боломжгүй болгон эвдсэн, түүнчлэн компьютер, мэдээллийн сүлжээнд хадгалагдаж байгаа мэдээллийг хууль бусаар хуулбарласан, мэдээллийн сүлжээгээр дамжуулж байгаа мэдээллийг замаас нь авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 50000-60000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

41 дүгээр зүйл.Садар самууныг сурталчлах,өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх

Садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

/Энэ хэсгийн торгуулийн хэмжээг 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчилсөн/

/Энэ зүйлийг 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ШҮҮХИЙН ТУХАЙ

1993-02-04

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

7 дугаар зүйл.Шүүгчийн бүрэн эрх

1.Бүх шатны шүүхийн шүүгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

б/албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

62 дугаар зүйл.Шүүгчийн улс төрийн эрх

**ЗУРГАДУГААР ЗҮЙЛ
ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА**

2.Шүүгч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛЬ

1993-02-15

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

6 дугаар зүйл. Сонгууль бэлтгэн явуулах ажлын ил тод байдал

2. Төрийн байгууллагын харьяалал бүхий хэвлэл, мэдээллийн байгууллага сонгууль бэлтгэн явуулах ажлын явц, сонгуулийн дүнг олон нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэй.

3. Төв, орон нутгийн сонин хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын нийтэлсэн мэдээлэл үнэн зөв байвал зохино.

7 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

6. Сонгуулийн зардлын санг нэр дэвшигчийг сурталчлах, сонгогчид той уулзах, хурал цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтны бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон албан томилолтын зэрэг Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан заавраар зөвшөөрсөн бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

8. Нэр дэвшүүлсэн нам болон сонгуульд хамтарч нэр дэвшүүлсэн намуудыг төлөөлөх байгууллага сонгуулийн зардлын сангийн зарцуулалтын тайланг дансны хөдөлгөөн зогсоосон өдрөөс хойш нэг сарын дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ. Сонгуулийн ерөнхий хороо уг тайланг хянан үзэж сонгууль дууссан өдрөөс хойш гурван сарын дотор дүнг төрийн төв хэвлэлд нийтэлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ

27 дугаар зүйл Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

1. Нэр дэвшигч хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өөрийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга, сурталчилгаа хийх, холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

4. Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

28 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа

2. Сонгуулийн сурталчилгааг санал хураах өдрөөс 24 цагийн өмнө зогсооно. Энэ үеэс эхлэн сонгууль явагдаж дуустал ямар нэг хэлбэрээр ухуулга, сурталчилгаа хийх, санал хураах өдөр хүртэл 7 хоногийн хугацаанд олон нийтийн саналасуулгавуулах, санал асуулгын дүн мэдээг нийтлэхийг хориглоно.

3. Улсын радио, телевиз, төрийн байгууллагын харьяалал бүхий сонин, сэтгүүлээр сонгуулийн ухуулга, сурталчилгаа үнэ төлбөргүй явуулах хугацаа, боломж нь нэр дэвшигч бүрт харилцан адил байна.

4. Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоож олгосон хугацаанаас бусад цагт улсын радио, телевиз, төрийн байгууллагын харьяа-лал бүхий сонин, сэтгүүлээр нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулбал үнэ төлбөрийг төлнө.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ САНАА ХУРААХ, АНХАН ШАТНЫ СОНГУУЛИЙН ДҮН ГАРГАХ

32 дугаар зүйл. Санал хураах ажлыг зохион байгуулах

1. Санал хураах өдрийн 07 цагт сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөлөгчдийг байлцуулан саналын бүх хайрцгийг шалган битүүмжилж, санал

хураах ажиллагааг эхэлнэ.Энэ ажиллагаанд намын ажиглагчид, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байлцаж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ

1993-05-06

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ

14 дүгээр зүйл.Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх

6.Төрийн удирдлагын хүрээн дэх мэдээллийн албыг зохион байгуулж, хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах нөхцөл бүрдүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮН

20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн

1. Ерөнхий сайд болон сайд нарын эрхлэх ажлын үндсэн хүрээнд дараах асуудал хамаарна:

1.үндэсний радио, телевизийн асуудал;

3/ Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд:

- хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагын бүртгэл;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийг хамгаалах асуудал;

7/ Монгол Улсын Дэд бүтцийн сайд:

- мэдээллийн технологийн бодлого;

24 дүгээр зүйл.Засгийн газрын гишүүний бүрэн эрх

1.Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар олгосон бүрэн эрхтэй.Түүний дотор:

3.Засгийн газрын гишүүн нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх, төрийн зүтгэлтний ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, төрийн болон албаны нууцыг хадгалах үүрэгтэй.

4.Засгийн газрын гишүүн шийдвэр, мэдэгдэл гаргах, аливаа хэлбэрээр албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ Ерөнхий сайдын бодлогыг баримтална.Хэрэв эрхэлсэн асуудлынхаа хүрээнд Ерөнхий сайдын бодлогыг зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай гэж үзвэл энэ тухай зохих шийдвэрийн төсөл бэлтгэж Ерөнхий сайдад уламжлан шийдвэрлүүлнэ.

25 дугаар зүйл.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

4.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

29 дүгээр зүйл.Засгийн газрын хуралдаан

4.Хуралдааныг Ерөнхий сайдын шийдвэрлэснээр нээлттэй буюу хаалттай явуулж болох бөгөөд хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

31 дүгээр зүйл.Засгийн газрын шийдвэрийг нийтлэх

1.Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрт Ерөнхий сайд гарын үсэг зурснаас хойш ажлын 3 хоногийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвшөөрснөөр Төрийн мэдээлэл эмхтгэлд албан ёсоор нийтлэхээс гадна Ерөнхий сайдын ажлын хэсгээс эрхлэн хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсэгт 1996 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон, мөн 2000 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар “төрийн төв хэвлэлд” гэснийг “төрийн мэдээлэл эмхтгэлд” гэж өөрчилсөн. /

2.Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрийг төв, орон нутгийн сонин, хэвлэлд нийтлэхдээ Төрийн мэдээлэл эмхтгэлд төрийн төв хэвлэлд нийтлэгдсэн албан ёсны эхийг баримтална.

/ Энэ хэсгийг 2000 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар “төрийн төв хэвлэлд” гэсэн заалтыг “төрийн мэдээлэл эмхтгэлд” гэж өөрчилсөн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

1993-04-23

ХОЁРДУГААР БҮЛЭГ ПРОКУРОРЫН ЭРХ ХЭМЖЭЭ

14 дүгээр зүйл.Прокурорын үндсэн бүрэн эрх

6.Прокурор хууль тогтоомж, түүнд нийцүүлэн Улсын ерөнхий прокуророос гаргасан журам, заавар, төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахих, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ЭРХ ЗҮЙН ХЭЛБЭР

26 дугаар зүйл.Прокурорын зөвшөөрөл

1.Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ПРОКУРОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА

29 дүгээр зүйл.Улс төрийн баталгаа

3.Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

43 дугаар зүйл.Прокурорын байгууллагын хэвлэл,эрдэм шинжилгээний байгууллага

Прокурорын байгууллага хууль хамгаалах бусад байгууллагатай хамтарсан хэвлэл, сургалт-эрдэм шинжилгээний байгууллагатай байж болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1993-06-05

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

9 дүгээр зүйл.Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж

3.Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх зарлиг түүнд өөрөөр заагаагүй бол төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа, бусад зарлиг, захирамж тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн зарлиг,захирамжийг нийтлэх

1.Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2.Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг төв, орон нутгийн сонин хэвлэлд нийтлэхдээ төрийн төв хэвлэлд нийтлэгдсэн албан ёсны эхийг баримтална.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАТАЛГАА**

16 дугаар зүйл.Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

1.Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:
5.Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ

1993-12-28

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ, БАТЛАХ

10 дугаар зүйл. Заавал соёрхон батлах олон улсын гэрээ
Заавал соёрхон батлах гэрээнд дараахь олон улсын гэрээ багтана:
1/Монгол Улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нутаг дэвсгэр, улсын хил болон хүний
салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ;

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ БҮРТГҮҮЛЭХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ, ХАДГАЛАХ

25 дугаар зүйл. Олон улсын гэрээг хэвлэн нийтлэх

1. Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан олон улсын гэрээг нийтлэхдээ
Монгол Улсын хууль нийтлэх журам, олон улсын бусад гэрээг нийтлэхдээ Засгийн газрын
тогтоол нийтлэх журмыг тус тус баримтална.

2. Олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн
захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХОТ ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

1993-12-20

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХОТ, ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН БҮРЭН ЭРХ

22 дугаар зүйл. Барилга, тээвэр, холбооны талаархи хот тосгоны захирагчийн
бүрэн эрх

5. Хот, тосгоны өөрийн мэдлийн радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг
чиглүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ

34 дүгээр зүйл. Хотын хэвлэл, мэдээлэл Хот сонин, сэтгүүл, радио, телевизтэй
байж болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

1993-12-02

ГУРАВДУГААР БҮЛЭГ
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ

26 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын ажлын шуурхай байдлыг хангах

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нимйгмийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж яваа үедээ
цагдаагийн байгууллага, алба хаагч дараахь эрх эдэлнэ:

2/гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээлэл шуурхай дамжуулахад байгууллага, иргэдийн холбооны хэрэгсэл ашиглах;

4/нийтэд түгээх яаралтай мэдээллийг хүн амд хүргэх шаардлага гарсан үед хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглах.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан тохиолдолд цагдаагийн байгууллага өмчийн хэлбэрийг нь харгалзахгүйгээртээврийн хөлс буюу гарсан шууд зардлыг төлнө.

Мөн хэсгийн 3,4-т заасан тохиолдолд цагдаагийн байгууллага төрийн өмчийн тээврийн болон хэвлэл, мэдээллийн хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглана. Харин бусад төрлийн өмчийн тээврийн болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашигласан бол холбогдох хөлс буюу гарсан шууд зардлыг төлнө.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хөлс, зардлыг цагдаагийн алба хаагч тухайн үед шууд төлөх боломжгүй бол тээврийн болон холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашигласан тухай албан ёсны баримт өгч, тооцоог нөхөн хийнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧ , ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

29 дүгээр зүйл. Цагдаагийн алба хаагч

7.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

36 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог
2.Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албанд хүндэтгэлтэй хандана.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

1993-12-24

8 дугаар зүйл. Хэвлэл, мэдээлэл, Засгийн газрын бус байгууллагын үүрэг

Хэвлэл, мэдээлэл, шашин олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нь дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хүн амын дунд зохиох сургалт, сурталчилгааны ажилд оролцох үүрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТАМХИНЫ ХОР ХӨНӨӨЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

1993-12-27

6 дугаар зүйл. Тамхи сурталчлахыг хориглох

Дараахь хэлбэрээр тамхи сурталчлахыг хориглоно:

1/хэвлэл, зурагт хуудас, кино, телевиз, радио, ханын самбар, зар чимэглэл, чөлөөт загвар болон бусад шууд хэлбэрээр биет байдлаар сурталчлах;
4/тамхины үйлдвэрлэл эрхэлдэг, тамхи дагнан борлуулдаг аж ахуйн нэгж ивээн тэтгэгчээр оролцож сурталчилгаа явуулах;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬ

1993-07-15

5 дугаар зүйл.Хураамж хураах үйлчилгээний төрөл
7/сонин, сэтгүүл бүртгэх;
12/зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэх;

17 дугаар зүйл.Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэхэд 250 төгрөг;

2/уг бүртгэлд өөрчлөлт оруулахад 100 төгрөг.

/Энэ зүйлд 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.

18 дугаар зүйл. Хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх

1.Шүүхэд гаргасан дараахь нэхэмжлэлийг хураамжаас чөлөөлнө:

2/патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

1994-07-05

БУСАД ЭРХ ТАВДУГААР БҮЛЭГ

22 дугаар зүйл.Нийслэлийн мэдээлэл, судалгааны байгууллага

1.Нийслэл Улаанбаатар хот нь өөрийн сонин, телевиз болон радиогийн нэвтрүүлэгтэй байж болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ

1994-05-20

ЗУРГАДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДУУЛАЛ, ТҮҮНИЙГ ЭГШИГЛҮҮЛЭХ, ХҮНДЭТГЭХ

21 дүгээр зүйл.Төрийн дууллыг эгшиглүүлэх

1.Төрийн дууллыг дараахь тохиолдолд эгшиглүүлнэ:

5/радио өргөн нэвтрүүлгийн үндсэн хөтөлбөр эхлэх, төгсөхөд;
6/бүх ард түмний баяр ёслолд зориулсан телевизийн хөтөлбөрийн анхны өдрийн нэвтрүүлэг эхлэхэд;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1994-05-24

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйл

Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах, түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараахь эд өлгийн болон оюуны үнэт зүйлийг өмчийн төрөл харгалзахгүйгээр түүх, соёлын дурсгалт зүйлд хамааруулна:

4/сурвалж бичиг, гар бичмэл, барын болон хэвлэмэл ном судар, аман зохиол зэрэг бичгийн дурсгал, гэрэл зураг, кино болон дүрс бичлэг;

10/эд өлгийн болон оюуны бусад зүйл.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ СУРВАЛЖЛАН ОЛОХ, СУДАЛЖ ЖИНЖЛЭХ, АШИГЛАХ

9 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, ашиглах

5.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хувиран олшруулах, загвараар нь бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, кино, дүрс бичлэг, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх журмыг Засгийн газар тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

1994-05-24

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

8 дугаар зүйл.Иргэний хамгаалалтын зарлан мэдээлэл

3.Хөнөөх хэрэгсэл, гамшиг, ослын хөнөөлийн үед иргэний хамгаалалтын зарлан мэдээллийн дохиог холбоо,мэдээллийн байгууллага өмчийнхөө хэлбэрээс үл хамааран үнэ төлбөргүй саадгүй дамжуулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

1994-05-09

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

8 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

4.Хаалттай хуралдааны явцад илэрхий болсон, түүнчлэн албан үүрэгтэй нь холбогдуулж шүүгчид итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг шүүгч, хуралдаанд оролцогчид задруулж болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ

1993-06-22

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

3 дугаар зүйл.Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл

1.Зохиогчийн эрхэд агуулга, зориулалт, хэлбэр бүтээсэн болон хүртээл болох аргаасаа үл шалтгаалан дараахь бүтээл хамаарна:
8/гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл;

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
БҮТЭЭЛИЙГ ДАЙЧЛАН АВАХ, ЗОХИОГЧИЙН
ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР АШИГЛАХ**

16 дугаар зүйл.Бүтээлийг нийтийн тусад нийцүүлэн хуулбарлах, олшруулах

Нийтийн хүртээл болсон бүтээлийг нийтийн тусад нийцүүлэн зохиогчийн нь зөвшөөрөлгүй, түүнд үнэ хөлс төлөхгүйгээрдараахь тохиолдолд зохиогчийн нэр болон бүтээлийн эх сурвалжийг дурдан хэсэгчлэн хуулбарлах буюу олшруулж болно:

1/архив, музей, номын санд тавигдсан бүтээлийг орлого олох зорилгогүйгээр ашиглах;
4/хараагүй хүмүүст зориулах;
5/судалгаа, шинжилгээ, шүүмжид зориулах;
6/болсон үйл явдлыг нийтэд мэдээлэхтэй холбогдуулан дүрслэх урлагийн болон хавсарга урлагийн бүтээлийг тогтмол хэвлэлд нийтлэх;
7/бүтээлийг гудамж, талбай зэрэг олон нийтийн газар байршуулсан бол.Харин түүнийг орлого олох зорилгоор ашиглавал зохиогчийн зөвшөөрлийг урьдчилан авч, түүнд төлөх үнэ хөлсний хэмжээг тохиролцсон байвал зохино;
8/худалдахаар буюу нийтэд үзүүлэхээр бэлтгэсэн бүтээлийг сурталчлах, зарлах;
9/хэвлэлд нийтлэгдсэн бүтээлийн талаар хэвлэлийн тойм бэлтгэх.

**ТАВДУГААР БҮЛЭГ
УРАН БҮТЭЭЛЧ, ДУУ АВИА, ДҮРС БИЧЛЭГ ҮЙЛДВЭРЛЭГЧ, РАДИО,
ТЕЛЕВИЗИЙН ЗОХИОГЧИЙН ЭРХТЭЙ ХОЛБОГДОХ ЭРХ**
20 дугаар зүйл.Үүсмэл бүтээл туурвигчийн зохиогчийн эрхтэй холбогдох эрх

1.Энэ хуулийн уран бүтээлчид холбогдох заалт нь дараахь хүмүүст хамаарна:

2/тоглолт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болж байгаа, энэ хуулиар хамгаалагдсан дуу авианы бичлэгт бичигдсэн, дуу авианы бичлэгт бичигдээгүй боловч энэ хуулиар хамгаалагдсан радио, телевизийн нэвтрүүлэгт орсон гадаадын иргэн буюу харьяалалгүй хүн.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан уран бүтээлч бүтээлийнхээ хувьд дараахь эрх эдэлнэ:

1/нэр хэрэглэх буюу нэрээ дурдуулах;

2/бүтээл нь халдашгүй байх;

3/бүтээлээ гэрээний үндсэн дээр аливаа арга хэлбэрээр бусдад ашиглуулах, түүний төлөө үнэ хөлс авах;

4/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх;

5/өөрийн бүтээл /тоглолт/-ийг бичлэгт буулгах, уг бичлэгийг бусад этгээд олшруулахад зөвшөөрөл олгох;

6/өөрийн бүтээл /тоглолт/-ийг нийтэд танилцуулах зорилгоор нэвтрүүлэх зөвшөөрөл олгох.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх журмаар туурвисан хамтын үүсмэл бүтээлийн туурвигчийн эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол уг бүтээлийг санхүүжүүлэгч /продюсор/ этгээд эдэлнэ.

21 дүгээр зүйл. Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зохиогчийн эрхтэй холбогдох эрх

1. Дуу авиа, дүрс билэг үйлдвэрлэгч зохиогчийн эрхтэй холбогдох дараахь эрх эдэлнэ:

1/дуу авиа, дүрс бичлэгээ хуулбарлах;

2/дуу авиа, дүрс бичлэгээ өөрчлөн найруулах;

3/дуу авиа, дүрс бичлэгээ олшруулан нийтийн хүртээл болгох;

4/дуу авиа, дүрс бичлэгээ гэрээний үндсэн дээр бусдад ашиглуулах, түүний төлөө үнэ хөлс авах;

5/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх.

2. Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүйгээр, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр нийтийн хүртээл болсон дуу авиа, дүрс бичлэгийг орлого олохзорилгогүйгээр ашиглах болно.

3. Дуу авиа, дүрс бичлэгийн олшруулсан хувийг хөлсөөр эдлүүлэх газраар дамжуулан нийтийн хүртээл болгох эрхийг зөвхөн уг дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч эдэлнэ.

4. Уран бүтээлч, дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зохиогчийн эрхийг хамгаалах хугацаа нь бичлэг хийгдсэн өдрөөс, эсхүл тоглолт болсон өдрөөс хойш 50 жил байна.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

5.Энэ зүйлд заасан дуу авиа, дүрс бичлэгийн хамгаалалтад дор дурдсан зүйл хамаарна:

1/Монгол Улсын иргэний үйлдвэрлэсэн дуу авиа, дүрс бичлэг;

2/Монгол Улсад анх үйлдвэрлэгдсэн дуу авиа, дүрс бичлэг;

3/Монгол Улсад анх нийтийн хүртээл болгосон дуу авиа, дүрс

бичлэг.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийнхуулиар нэмсэн/

22 дугаар зүйл. Радио, телевизийн байгууллагын зохиогчийн эрхтэй холбогдох эрх

1. Радио, телевизийн байгууллага зохиогчийн эрхтэй холбогдох дараахь эрх эдэлнэ:

- 1/өөрийн нэвтрүүлгийг нэгэн зэрэг нэвтрүүлэх эрхийг бусад радио болон телевизийн байгууллагад олгох;
- 2/телевизийн байгууллага радиод, радиогийн байгууллага телевизэд нэвтрүүлэг дамжуулах;

3/нэвтрүүлгийн бичлэгийг хуулбарлах;

4/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх.

2. Радио, телевизийн байгууллагын зохиогчийн эрхтэй холбогдох эрхийн хугацаа уг нэвтрүүлгийг анх нэвтрүүлсний дараа жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн 25 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Энэ хугацаанд радио, телевизийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр уг нэвтрүүлгийг хуулбарлах, дамжуулан нэвтрүүлэх, бичлэг ашиглан нэвтрүүлэх зэргээр нийтэд танилцуулахыг хориглоно.

3. Энэ зүйлд заасан радио, телевизийн нэвтрүүлгийн хамгаалалтад дор дурдсан зүйл хамаарна:

1/төв байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байрладаг радио, телевизийн байгууллагын нэвтрүүлэг;

2/Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байрладаг дамжуулагчаас дамжуулсан радио, телевизийн нэвтрүүлэг.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

23 дугаар зүйл. Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч, үүсмэл бүтээл туурвигч болон радио, телевизийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтээлийг ашиглах

Үүсмэл бүтээл болон дуу авиа, дүрс бичлэг, радио, телевизийн нэвтрүүлгийг нийтийн тусад нийцүүлэн холбогдох этгээдийн нь зөвшөөрөлгүйгээр, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр дараахь тохиолдолд хэсэгчлэн танилцуулж болно:

1/радио, телевизийн нэвтрүүлгээр үүсмэл бүтээл болон дуу авиа, дүрс бичлэг нэвтрүүлэх;

2/сургалт болон эрдэм шинжилгээний ажилд ашиглах;

3/мэдээлэх зорилгоор иш татан хэрэглэх.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ПАТЕНТЫН ТУХАЙ

1993-06-25

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг хамгаалах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

/Энэ зүйлд 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд:

4/"патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, эсхүл бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

6/"лиценз" гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг бусдад ашиглуулах зөвшөөрлийг;

9/"патент эзэмшигч" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент болон ашигтай загварын гэрчилгээ, түүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээдийг;

/Энэ заалтыг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

10/"Монгол Улсын олон улсын гэрээ" гэж Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц /1883/ болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Бүтээгдэхүүний загварын олон улсын хадгалалтын тухай Гаалийн хэлэлцээр /1960/, Патентийн хамтын ажиллагааны гэрээ /1970/, Дэлхийн худалдааны байгууллагын Оюуны өмчийн эрхийн худалдаанд хамаарах хэлэлцээр/1994/-ийг;

/Энэ заалтыг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

11/"Патентийн хамтын ажиллагааны гэрээнд нийцсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг" гэж конвенцийн давамгайлах огноо бүхий Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загвар, мэдүүлгийг тус тус ойлгоно.

/Энэ заалтыг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

4 дүгээр зүйл. Патент олгох зүйл, шалгуур

1. Шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой, цоо шинэ үйлдвэрлэх арга ажиллагаа буюу бүтээгдэхүүн /шинэ бүтээл/ зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно.

2. Шинэ бүтээл нь тухайн мэргэжлийн хүнд ялгагдах давуу шинж чанартай байвал түүнийг шинэ бүтээлийн түвшин агуулсан гэж үзнэ. Шинэ бүтээлийн түвшинг Оюуны өмчийн газраас эрх олгосон шинжээч тодорхойлно.

6. Мэдүүлэг хүлээн авах хүртэл дэлхийн аль нэг оронд хэвлэгдээгүй, тус улсад ямар нэг замаар тархаж мэдэгдээгүй, үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүүний хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц, цоо шинэ шийдэл /бүтээгдэхүүний загвар/ зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно.

5 дугаар зүйл. Оюуны өмчийн газар

1. Монгол Улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварлын асуудлыг Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Оюуны өмчийн газар хариуцан дараахь чиг үүргийг гүйцэтгэнэ:

/Энэ хэсэгт 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэх;

2/патент, ашигтай загварын гэрчилгээ олгох;

/Энэ заалтад 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, лицензийн гэрээний улсын бүртгэл хөтлөх;

/Энэ заалтад 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

4/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

/Энэ заалтад 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

5/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн тухай мэдээллийг хэвлэн нийтлэх;

/Энэ заалтад 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

6/патенттай холбогдсон маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөх;

7/патент, ашигтай загварын гэрчилгээний загварыг тогтоох.

/Энэ заалтад 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

8/хуулийн этгээд, иргэдийг патентийн тухай хууль зөрчсөн гэж үзвэл холбогдох байгууллагад мэдэгдэх;

9/хуульд заасан үндэслэл, журмын дагуу патентийг хүчингүйд тооцох;

10/ бүтээлийн зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг төлөөлөн хамгаалах;
11/патентийн хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрх хэмжээнийхээ дотор зохион байгуулах;

12/патентийн асуудалтай холбоотой өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;
13/патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулж зөвшөөрөл олгох;

14/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын үнэлгээг зохиогчийн хүсэлтээр тогтоох;

/Энэ заалтад 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

15/оюуны өмчийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах.

/Энэ заалтыг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

16/эрхлэх асуудлаар байгууллага албан тушаалтнаас холбогдох баримт бичгийг гаргуулж авах.

/Энэ хэсгийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2.Оюуны өмчийн газар үйл ажиллагааныхаа орлогоор санхүүжүүлнэ.

/Энэ хэсгийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.Оюуны өмчийн газрын дүрмийг Засгийн газар батална.

4.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын ажлыг технологийн бодлогынхоо бүрэлдэхүүн хэсэг болгон явуулна.

/Энэ хэсэгт 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШИНЭ БҮТЭЭЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР, АШИГТАЙ ЗАГВАРЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ, ТҮҮНД ШҮҮЛТ ХИЙХ

/Энэ бүлгийн нэрэнд 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

6 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргах

1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд Оюуны өмчийн газарт гаргана.

2.Шинэ бүтээл тус бүрд мэдүүлэг гаргана.Нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт нэг мэдүүлэг гаргаж болно.

/Энэ хэсэгт 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3.Шинэ бүтээлийн мэдүүлэг нь өргөдөл, шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, товч тайлбараас бүрдэнэ.Шаардлагатай бол түүнд холбогдох зураг, магадлагааг хавсаргана.

5.Өргөдөлд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогч, мэдүүлэг гаргагч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, мэдүүлэг гаргасан огноо, патент авах хүсэлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын нэрийг тусгана.Мэдүүлэг гаргагч нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогч биш байвал шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент авах эрхээ нотолсон баримтыг хавсаргана.

6.Мэдүүлэг гаргагч өргөдөлдөө үндэсний, бүсийн, олон улсын мэдүүлгийн огноог давамгайлах огноогоор тогтоолгох тухай хүсэлтээ илэрхийлж болно. Парисын конвенцийн болон Дэлхийн худалдааны байгууллагын аль нэг гишүүн оронд давамгайлах огноо хүсэж гаргасан мэдүүлгийн хуулбарыг Оюуны өмчийн газрын хүсэлтээр хавсаргана.

/Энэ хэсэгт 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

7.Мэдүүлэг гаргагч нь өөрийгөө итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Оюуны өмчийн газарт бүртгүүлнэ.

Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг Оюуны өмчийн газар тогтооно.

Патентийн итгэмжлэгдсэн төлөөлөгч дээд боловсролтой, оюуны өмчийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, Монгол Улсын 25 насанд хүрсэн иргэн байна.

/Энэ хэсэгт 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт орсон.

9.Олон улсын нэг ангилалд хамаарах адил төстэй 50 хүртэл бүтээгдэхүүний загварыг нэг мэдүүлгээр мэдүүлж болно.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

61 дугаар зүйл. Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу олон улсын мэдүүлэг гаргах

1.Монгол Улсыг нэр зааж гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын олон улсын мэдүүлгийн анхдагч огноог энэ хуулиар, эсхүл Патентийн хамтын ажиллагааны гэрээний дагуу бүртгүүлсэн олон улсын бүртгэлийн огноогоор тогтооно.

8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

1.Оюуны өмчийн газар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж шаардлага хангасан гэж үзвэл мэдүүлэг хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтооно.

10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

1.Мэдүүлгийн анхдагч огноог тогтоосны дараа Оюуны өмчийн газар тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан шалгуур хангасан эсэхэд шүүлт хийнэ.

5.Оюуны өмчийн газар мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана. Шаардлагатай гэж үзвэл Оюуны өмчийн газар энэ хугацааг 12 хүртэл сараар сунгаж болно.

6.Патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентын хэвлэлд нийтэлж зарлана.

7.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болох нь нотлогдоогүй бол шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлж, мэдүүлгийг патентын санд хадгална.

12 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент олгох

1.Шинэ бүтээлийн ном зүй, товч мэдээлэл, бүтээгдэхүүний загварын зургийг патентын хэвлэлд нийтэлсэн өдрөөс хойш 3 сарын дотор Оюуны өмчийн газарт няцаасан нотолгоо ирээгүй, маргаан гараагүй бол Оюуны өмчийн газар патент олгоно.

Мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 10 жилийн хугацаанд патент авах хүсэлтийг гаргана.
/Энэ хэсэгт 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт, 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Няцаасан нотолгоо ирсэн, маргаан гарсан тохиолдолд тэдгээрийг зохих журмын дагуу шийдвэрлэх хүртэл патент олгохыг хойшлуулна.

3.Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг улсын бүртгэлд бүртгэж, мэдүүлгийг нь патентын санд хадгална.

14 дүгээр зүйл. Патент, ашигтай загварын гэрчилгээний хүчинтэй байх хугацаа

Патент олгосон огнооноос эхлэн шинэ бүтээлийн патент 20 жил, бүтээгдэхүүний загварын патент 10 жил, ашигтай загварын гэрчилгээ 7 жилийн хугацаанд тус тус хүчинтэй байна.

/Энэ зүйлд 1996 оны 12 дугаар сарын 19, 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиудаар тус тус өөрчлөлт орсон/

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ШИНЭ БҮТЭЭЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР, АШИГТАЙ ЗАГВАР ЗОХИОГЧ БОЛОН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

/Энэ бүлгийн нэрэнд 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

15 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогчийн эрх

1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогч дараахь эрх эдэлнэ:

1/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа өмчлөх;

2/патент авах эрхээ бусдад шилжүүлэх;

3/шинэ бүтээл;

4/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын технологийн баримт

бичиг боловсруулах, тэдгээрийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд оролцож зохиогчийн хяналт тавих;

5/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа ашиглууснаас олсон орлогоос зохих хэмжээний шан хөлс авах.

/Энэ хэсгийн 5 дахь заалтыг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

2. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар хамтран сэдэж бүтээсэн зохиогчид патент авах эрхийг хамтран эдэлнэ.

Хамтран зохиогч бусдынхаа зөвшөөрөлгүйгээр патент авах эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

3. Ижил шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг тусдаа сэдэж бүтээсэн бол мэдүүлгээ Оюуны өмчийн газарт түрүүлж өгсөн зохиогч, харин давамгайлах огноо мэдүүлсэн тохиолдолд түрүү давамгайлах огноотой мэдүүлэг өгсөн зохиогч патент авах эрх эдэлнэ.

17 дугаар зүйл. Патент эзэмшигчийн эрх

1. Патент эзэмшигч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа ашиглах онцгой эрх эдэлнэ.

2. Патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг зөвхөн патент эзэмшигчийнх нь зөвшөөрлөөр ашиглана.

3. Патент эзэмшигч патент эзэмших эрхээ бусдад шилжүүлэх эрх эдэлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ШИНЭ БҮТЭЭЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР, АШИГТАЙ ЗАГВАРЫГ АШИГЛАХ

/Энэ бүлгийн нэрэнд 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

18 дугаар зүйл. Патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах

1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, хэрэглэх болон энэ зорилгоор хадгалах, гадаадаас оруулах үйлдлийг шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашигласан гэж үзнэ.

2. Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг дараахь байдлаар ашиглавал патент эзэмшигчийн онцгой эрхийг зөрчсөн гэж үзэхгүй:

1/патент эзэмшигч өөрөө, эсхүл түүний зөвшөөрөлтэйгээр бусад этгээд тус улсын зах зээлд гаргасан бүтээгдэхүүнийг ашиглах;

2/тус улсад эрдэм шинжилгээ, сорилт туршилтын ажилд ашиглах;

3/тус улсын нутаг дэвсгэрт түр буюу тохиолдлоор орж ирсэн

бусад орны тээврийн хэрэгсэлд ашиглах.

3. Мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө өөр этгээд тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглаж байсан буюу ашиглах бүх нөхцөлийг урьдчилан

бүрдүүлсэн бол тэдгээрийг патент эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүй ашиглаж болно. Харин тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах хэмжээ, хүрээг өргөтгөж болохгүй.

4. Оюуны өмчийн газар патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг үр дүнтэй ашиглах зорилгоор шинэ бүтээлийн улсын нөөцийн сан бий болгоно. Санг бүрдүүлж буй бүтээлийн патент эзэмших эрхийг патент эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр Оюуны өмчийн газар эдэлнэ.

/Энэ хэсгийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн ба түүнд 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт орсон//

19 дүгээр зүйл. Лицензийн гэрээ

1. Сонирхогч этгээд патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг патент эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулан ашиглана.

2. Лицензийн гэрээнд дараахь зүйлийг тусгана:

1/ шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах арга, хэлбэр, хэмжээ, хүрээ, хугацаа;

2/ гэрээний талуудын эрх, үүрэг;

3/ шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашигласны төлбөрийн хэмжээ, түүнийг олгох журам.

3. Лицензийн гэрээг Оюуны өмчийн газарт бүртгүүлнэ.

6. Лицензийн гэрээ нь гуравдагч этгээдийн ашиг сонирхолд харшлахгүй байх бөгөөд гэрээний талууд гэрээний нууцыг чанд хадгална.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7. Патент эзэмшигч өөрийн шинэ бүтээлээ сонирхогч этгээдэд чөлөөтэй ашиглуулах лиценз олгох тухай хүсэлтээ Оюуны өмчийн газарт гаргаж болно.

/Энэ хэсгийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

8. Лицензийн гэрээг шударга өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн нөхцөлтэйгээр байгуулж болохгүй.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

20 дугаар зүйл. Лиценз албадан хэрэглэх

1. Патент бүхий шинэ бүтээлд сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу Оюуны өмчийн газрын шийдвэрээр дараахь тохиолдолд лиценз албадан хэрэглэж болно:

1/ шинэ бүтээлийг үндэсний аюулгүй байдал, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн заавал ашиглавал зохих;

2/ мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 4 жил буюу патент олгосон өдрөөс хойш 3 жил /аль сүүлд хугацааг тооцно/-ийн хугацаанд шинэ бүтээлийг огт ашиглаагүй тохиолдолд тухайн шинэ бүтээлийг Монгол Улсад ашиглах нөхцөл байгаагүйг Оюуны өмчийн газарт патент эзэмшигч нотолж чадаагүй;

3/ лицензийн гэрээгээр патент бүхий бүтээлийг ашиглаж байгаа байдал нь шударга бус өрсөлдөөний шинжийг агуулсан гэж патент эзэмшигч үзвэл.

/Энэ заалтыг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2. Лиценз албадан хэрэглэх тухай Оюуны өмчийн газрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол патент эзэмшигч гомдлоо шүүхэд гаргаж болно.

3. Лиценз албадан хэрэглэх тухай гэрээ хийх нөхцөлд патент бүхий бүтээл ашигласны төлбөрийг лиценз авагч тал патент эзэмшигчид төлнө.

/Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/

22 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар ашиглах аж

ахуйн нэгж, байгууллага болон патент эзэмшигчийн үүрэг

/Энэ зүйлийн нэрэнд 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/
1.Аж ахуйн нэгж, байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглахдаа олсон ашгийг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж үйлдвэрлэлийн нууцыг нь хадгална.

/Энэ хэсэгт 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигч өөрчлөгдөхөд энэ тухай бичгээр Оюуны өмчийн газарт мэдэгдэх ба энэ өөрчлөлт нь гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөхгүй ./Энэ хэсгийг 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

23 дугаар зүйл.Улсын нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар

Улсын нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт хамаарах харилцааг хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл.Патент, лицензийн хураамж

1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах патентийг хүчинтэй байлгах, лицензийн гэрээг бүртгүүлэхэд хураамж төлнө.Хураамжийг Оюуны өмчийн газар хураана.

/Энэ хэсэгт 1999 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/

2.Хураамжийн хэмжээг хуулиар тогтооно.

25 дугаар зүйл.Патентын хураамж төлөх хугацаа

1.Патентыг хүчинтэй байлгах хураамжийг тогтоосон хугацаагаар төлнө.

2.Патентыг хүчинтэй байлгах эхний 3 жилийн хураамжийг патент олгох шийдвэр гарсан өдрөөс хойш 6 сарын дотор, дараахь хугацааны хураамжийг тухайн хугацаа эхлэхээс 6 сарын өмнө тус тус төлнө.

3.Хэрэв патент эзэмшигч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд патентыг хүчинтэй байлгах хураамжийг төлөөгүй бол хугацаа өнгөрснөөс хойш 6 сарын дотор төлж болно.Энэ тохиолдолд тухайн хугацааны хураамжтай тэнцэх хэмжээний төлбөр нэмж төлнө.

4.Патентийг хүчинтэй байлгахыг сонирхогч этгээд патент эзэмшигчийн зөвшөөрлөөр патентийн хураамжийг төлж болно.

/Энэ хэсгийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/

26 дугаар зүйл.Патентыг хүчингүйд тооцох

1.Сонирхогч этгээд патентыг хүчингүй болгох тухай шүүхэд өргөдөл гаргаж болно.

2.Энэ хуулийн 4,6,8,10,12 дугаар зүйлд заасныг зөрчиж патент олгосон байвал шүүх патентыг хүчингүй болгоно.Энэ тохиолдолд Оюуны өмчийн газар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын улсын бүртгэлд зохих өөрчлөлтийг оруулж патентын хэвлэлд нийтэлнэ.

3.Патент эзэмшихээс болон патентын хураамж төлөхөөс татгалзсан, хураамжийг энэ хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Оюуны өмчийн газар патентыг хүчингүй болгоно.Энэ тохиолдолд төрийн хяналтад зайлшгүй байх шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент эзэмших эрх төрийн захиргааны холбогдох төв байгууллагад шилжинэ.

4.Патентийн хураамжийг төлөөгүй шалтгаанаар патентийг хүчингүйд тооцсон нөхцөлд патент хүчинтэй бэйх нийт хугацааны дотор патент эзэмшигчийн хүсэлтээр патентийг сэргээж болно.

/Энэ хэсгийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний хуулиар нэмсэн/

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

27 дугаар зүйл. Гомдол, маргаан шийдвэрлэх

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбогдон гарсан гомдлыг Оюуны өмчийн газар 6 сарын дотор хянан шийдвэрлэж хариуг бичгээр мэдэгдэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл маргалдагч тал шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

/Энэ зүйлийг 1996 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ

1994-07-07

7 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийхийг хориглох газар

1. Дараахь байгууллага оршин байгаа газар энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар жагсаал, цуглаан хийхийг хориглоно:
3/радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ

1994-11-17.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭРДЭНЭСИЙН САНГ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

12 дугаар зүйл. Эрдэнэсийн сангийн бүртгэл, тооцоо

2. Эрдэнэсийн сангийн нэгдсэн бүртгэл нь төрийн нууцад хамаарах бөгөөд Засгийн газар, Монголбанкинд тус бүр нэг хувь хадгалагдана.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ

1994-12-09

ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨМГӨӨЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА

13 дугаар зүйл. Өмгөөлөгчийн үүрэг

1. Өмгөөлөгч нь дараахь үүрэг биелүүлнэ
З/өмгөөлөл, төлөөллийн үүрэг гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүн болон өмгөөлүүлэгч, төлөөлүүлэгчийн нууцыг задруулахгүй байх;

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

1994-12-30

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ

13 дугаар зүйл. Төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг үүрэг

- Төрийн албан хаагч нь дараах нийтлэг үүрэг хүлээнэ
- 7/албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

1995-04-17

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ЗҮЙЛ

7 дугаар зүйл. Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг

1. Өргөдөл, гомдлын талаар төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх нийтлэг үүрэг
5/өргөдөл, гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

1995-06-19

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА**

7 дугаар зүйл. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

1. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна. Дээд боловсролын байгууллага нь эрдэм шинжилгээний хүрээлэн, дадлагын газар, номын сантай байхаас гадна факультет, салбар, соёл-спортын төв, туршилт-дадлагын газар, судалгааны төв, хэвлэл-мэдээллийн алба зэрэг нэгжтэй байж болно.

23 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1995-03-30

**ДОЛДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

36 дугаар зүйл. Экологийн боловсрол, хүмүүжил

1. Засгийн газар албан болон албан бус боловсролын тогтолцооны хүрээнд иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, байгаль орчныг хамгаалах арга, дадал олгох хөтөлбөрийг баталж биелэлтийг зохион байгуулна.

З/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.

2. Экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

З/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.

39 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 6 дугаар Энэ хуулийг 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ

1995-04-18

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь төрийн нууцыг тогтоох, хамгаалах,ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн нууцын тухай хууль тогтоомж

Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Төрийн нууцын тухай ойлголт

1."Төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх

тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал Монгол Улсын аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

2.Монгол Улсын аюулгүй байдлыг хангах үүднээс зарим барилга, байгууламж /цаашид "объект" гэх/, төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулж болно.

4 дүгээр зүйл.Төрийн нууцыг тогтоох зарчим

Төрийн нууцыг тогтоохдоо хууль тогтоомжид нийцсэн, цаг үеэ олсон байх зарчим баримтална.

5 дугаар зүйл.Төрийн нууцад хамааруулах зүйлийн хүрээ

1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд:

1/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээ, баримт бичиг, бусад зүйлийн нууцалбал зохих хэсэг;
2/Монгол Улсын гадаад бодлого, байр суурьтай холбоотой онц чухал мэдээлэл, түүнчлэн Монгол Улсаас гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл.

2.Батлан хамгаалах хүрээнд:

1/батлан хамгаалах бодлого, үзэл баримтлал, цэргийн номлол, тэдгээртэй холбогдох баримт бичгийн нууцалбал зохих хэсэг;
2/стратегийн, оперативын төлөвлөгөө, түүний биелэлтийн мэдээ, цэргийн стратеги, оператив, дайчилгааны дэлгэн байгуулалт, операц, байлдааныг бэлтгэх, хэрэгжүүлэх байлдааны удирдлагын баримт бичиг, зэвсэгт тэмцэл явуулах арга, байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, дайчилгааны нөөц, түүний ашиглалтын тухай мэдээлэл;
3/цэргийн зэвсэг техникийг шинээр бий болгох, худалдан авах, боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил, энэ зорилгоор хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, тэдгээрийн биелэлт, үр дүн;
4/нууц зэвсэг, түүнчлэн техник хэрэгслийн нэр, төрөл, техникийн өгөгдөхүүн, байлдаанд ашиглах боломж;
5/улсыг батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий объектуудын байрлал, зориулалт, бэлэн байдлын зэрэглэл, хамгаалалт, тэдгээр объектын зураг төсөл, дагалдах баримт бичиг, зардлын төсөв, объект барьж байгуулахаар олгосон газар нутаг, холбогдох бусад мэдээлэл
6/зэвсэгт хүчин, бусад цэргийн анги, салбарын зориулалт, зэвсэг, техникийн хангалт. нууцалсан болон тусгай томилгоот байрлал, жинхэнэ нэр, зэвсэглэл, бие бүрэлдэхүүний тоо;
7/Монгол Улсын яам, тусгай газар, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, жилийн тооцоот хэрэгцээний захиалга, төлөвлөгөө;
8/иргэний хамгаалалтын нийтийн дайчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх болон онцгой нөхцөл байдлын үед хүн амын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, хангалтын объектуудын байрлал, зориулалт, энэ үед дэд бүтцийг ашиглахтай холбогдсон мэдээлэл;
байгуулалт, арга ажиллагаа, тэдгээрт холбогдох мэдээлэл.

3.Эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологийн хүрээнд:

1/Монгол Улсын аюулгүй байдал, эдийн засаг, батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, туршилт, нээлт, зураг төсөл, үндэсний болон дэвшилтэт технологи;
2/цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон дайчилгааны хүчин чадал, улсын материаллаг нөөцийн бодит хэмжээ, байрлал;
3/батлан хамгаалах болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий стратегийн түүхий эд, материалын нөөц, олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ;
4/төрийн нууцыг хамгаалах арга хэрэгсэл, энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн тухай мэдээлэл.

4.Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд:

1/тагнуул, сөрөх тагнуулын үйл ажиллагаа, гүйцэтгэх ажлын арга хэлбэр, хүч хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж, орон тоо, зохион байгуулалт, баримт бичиг, архив, мэдээллийн сан, санхүүжилтийн тухай мэдээлэл;
2/төрийн холбооны нууцлал бүхий систем, түүнд холбогдох баримт бичиг, төрийн шифр, түүнийг ашиглах арга, ажиллагаа.
3/цагдаа, тагнуул, хорих байгууллагын галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, нөөц, нийтийн эмх замбараагүй байдлын үед тагнуул, цагдаагийн байгууллага, дотоодын цэргийн ажиллах төлөвлөгөө, улсын онц чухал объектын хамгаалалтын хүч хэрэгслийн тухай мэдээлэл, дайны болон дайн бүхий байдлын үед хорих байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох бусад баримт бичиг;
4/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа.

5.Цаазаар авах ялыг гүйцэтгэх журам, энэ зүйлийн 2 дахь хэсгийн "4, 5", 3 дахь хэсгийн "2, 3", 4 дэх хэсгийн "1"-тэй холбоотойгоор төрийн нууцад хамааруулах шаардлагатай объектууд.

6 дугаар зүйл. Төрийн нууцын жагсаалт

1.Төрийн нууцын жагсаалтыг хуулиар батална.

2.Хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулахыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦЫГ ТОГТООХ, НУУЦЛАХ

7 дугаар зүйл.Төрийн нууцыг тогтоох

Төрийн нууцыг тогтоох үйл ажиллагаа нь мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцын жагсаалтад хамааруулах шийдвэр гаргах, боловсруулах, нууцлах ажиллагаанаас тус тус бүрдэнэ.

8 дугаар зүйл.Төрийн нууцыг боловсруулах

1.Байгууллага, албан тушаалтан нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг боловсруулах, биет зүйлийг хийх, үйлдвэрлэх, объект барьж байгуулах, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх /цаашид "төрийн нууцыг боловсруулах" гэх/-дээ энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д заасан журмыг баримтална:

2.Байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг боловсруулахад өгч буй санал, дүгнэлт нь тухайн зүйлийг төрийн нууцад хамааруулахад хүргэж буй мэдээллийг агуулсан байвал тэдгээрийг нууцын зэрэглэлтэйд адилтган тооцож хамгаалалтад авна.

3.Төрийн нууцад хамаарах зүйлийн тухай асуудлыг энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д заасан журмыг баримтлан хаалттай хэлэлцэнэ.

9 дүгээр зүйл.Төрийн нууцад хамааруулах шийдвэр гаргах

1.Мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцын жагсаалтад хамааруулах саналыг байгууллага, албан тушаалтан, иргэдээс Тагнуулын төв газарт гаргана.

2.Тагнуулын төв газар тухайн саналыг судлан боловсруулж Засгийн газарт 2 долоо хоногийн дотор оруулна.

3.Засгийн газар төрийн нууцад хамааруулах тухай асуудлыг нарийвчлан судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулан ЗО хоногийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

4.Төрийн нууцын жагсаалтад мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хамааруулах тухай шийдвэр гаргахдаа нууцын зэрэглэлээс нь хамааран тэдгээрийн жинхэнэ нэрийг төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж болно.

10 дугаар зүйл.Төрийн нууцыг нууцлах

1.Мэдээ, баримт бичиг, биет зүйлийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ.

2.Мэдээ, баримт бичгийг нууцлахдаа төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдэг дарж, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаарыг тавина.

3.Биет зүйлийг нууцлахдаа нууцын тэмдэг, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаарыг тухайн зүйлийн сав, баглаа боодол, дагалдах баримт бичигт дарж тэмдэглэнэ.

4.Объект, тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл.Төрийн нууцын зэрэглэл

1.Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно.

2.Төрийн нууц нь дараахь зэрэглэлтэй байна:

1/онц чухал-маш нууц;

2/маш нууц;

3/нууц.

3.Мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулахаар Тагнуулын төв газарт санал оруулсан өдрөөс эхлэн шаардлагатай бол тэдгээрийг "онц чухал-маш нууц" зэрэглэлтэйд тооцож хамгаалалтад авна.

4.Төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдгийг төрийн нууцад үл хамаарах мэдээ, баримт бичиг, бусад зүйлд хэрэглэхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ, ХАРИУЦАХ

12 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах

1.Төрийн нууц нь төрийн хамгаалалтад байна.

2."Төрийн нууцыг хамгаалах" гэж төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг задруулахгүй байх зорилгоор өөрийн бүрэн эрхийн хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, арга хэрэгслийн цогцолборыг ойлгоно.

3."Төрийн нууцыг хариуцах" гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас төрийн нууцыг хамгаалах, хадгалах, ашиглах үйл ажиллагааг хамааруулан ойлгоно.

4.Төрийн нууцыг хариуцдаг, эсхүл төрийн нууцтай албан үүргийн дагуу танилцсан албан тушаалтан, иргэн төрийн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

5.Төрийн нууцыг олж авах зорилгоор хайх, бусдад тараахыг хориглоно.

13 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах талаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын бүрэн эрх

1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/Улсын Их Хурал:

а/төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

б/Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын саналыг үндэслэн төрийн нууцын зэрэглэлийг баталж төрийн нууцын хугацааг тогтоох, сунгах болон төрийн нууцыг ил болгох асуудлыг шийдвэрлэх;

в/нууцын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.

2/Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд:

а/төрийн нууцын хамгаалалтын талаар Засгийн газрын мэдээллийг сонсох, чиглэл өгөх, төрийн нууцыг хамгаалах талаар холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай танилцах;

б/төрийн нууцыг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, объект, тодорхой үйл ажиллагааг халхлах, төрийн нууцтай танилцах, төрийн нууцыг шилжүүлэх, татан авах, хаалттай хуралдаан хийх журмыг батлах.

3/Монгол Улсын Засгийн газар:

а/төрийн нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удир-даж, төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

б/төрийн нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шалгах.

2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар нь төрийн нууцыг хамгаалах талаар хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл.Төрийн нууцыг хариуцаж буй байгууллагын бүрэн эрх

1.Төрийн нууцыг хариуцаж байгаа төрийн бүх шатны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/салбарынхаа хэмжээнд хадгалагдаж байгаа болон бусад байгууллагын хариуцаж буй өөрийн салбарт хамаарах төрийн нууцын ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;

2/мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулах, зэрэглэл тогтоолгох, түүнчлэн төрийн нууцыг ил болгох асуудлаар Тагнуулын төв газарт саналаа оруулах;

3/төрийн нууцыг шилжүүлэх, татан авах тухай саналаа Тагнуулын төв газарт оруулах;

4/төрийн нууцыг тухайн байгууллага хариуцаж буй эсэх талаар хөндлөнгийн этгээдэд тайлбар өгөхөөс татгалзах;

5/эрх хэмжээнийхээ хүрээнд төрийн нууцыг хамгаалах тай холбогдсон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

2.Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга нь төрийн нууцыг хамгаалах ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд асуудлыг зохих журмаар холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.Байгууллага нь өөрт хадгалагдаж байгаа төрийн нууцыг хариуцаж, түүнийг хамгаалах арга хэмжээг хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан журамд нийцүүлэн зохион байгуулна.

15 дугаар зүйл. Тагнуулын төв газрын бүрэн эрх

1.Тагнуулын төв газар нь төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг улсын хэмжээнд зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүлээж, дараахь бүрэн эр-хийг хэрэгжүүлнэ:

1/төрийн нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэм-жээ авах;

2/төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллага, албан тушаалтан төрийн нууцыг хэрхэн ашиглаж, хамгаалж байгаад хяналт тавих, шалгах;

3/төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомж, Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг боловсронгуй болгох саналаа Засгийн газарт оруулах;

4/мэдээ, баримт бичиг, биет зүйлийг төрийн нууцад хамааруулах, төрийн нууцыг татан авах, шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэлийг тогтоох, төрийн нууцын хугацааг сунгах асуудлаар саналаа боловсруулж Засгийн газарт оруулах;

5/төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг дамжуулах төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны сүлжээгээр үйлчлэх;

6/төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийг үгүй болгосон, төрийн нууцыг задруулсан тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

7/хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрх.

2.Төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны дүрмийг Засгийн газар батална.

16 дугаар зүйл. Төрийн нууцыг хариуцуулах

1.Төрийн нууцыг хариуцах нууцын ажилтныг уул ажилд авахын өмнө тагнуулын байгууллага шалгаж зөвшөөрөл олгоно.

2.Тагнуулын байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг хариуцуулахыг хориглоно.

17 дугаар зүйл. Нууцын ажилтны эрх зүйн байдлын зарим онцлог

Нууцын ажилтан нь дараахь эрх зүйн байдлын онцлогтой байна:

1/гадаадад хувийн хэргээр зорчих тохиолдолд зохих байгууллагын зөвшөөрөл авах;

2/гадаадын иргэн, байгууллагатай албан бус харилцаа тогтоосон бол энэ тухай байгууллагадаа мэдэгдэх;

3/хариуцаж байгаа төрийн нууцын зэрэглэл, ажилласан хугацаанаас хамааран тухайн байгууллагад тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл авах.

18 дугаар зүйл. Төрийн нууцыг хариуцуулахыг зогсоох

1.Нууцын ажилтан хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд захи-гааны шийдвэрээр төрийн нууц хариуцуулахыг зогсоож, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.Төрийн нууц хариуцуулахыг зогсоосон нь төрийн нууцыг задруулахгүй байх талаар уул этгээдийн урьд хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ, ТҮҮНИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ТАТАН АВАХ

19 дүгээр зүйл.Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан

1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нь танилцуулахыг хуулиар хориглосноос бусад төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

2.Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаалтан нь албан үүргийншаардлагаар танилцвал зохих төрийн нууцтай энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д заасан журмын дагуу танилцана.

3.Төрийн нууцтай холбогдсон асуудлыг хянан шалгах зорилгоор Улсын Их Хурлаас байгуулсан комиссын гишүүн, эсхүл мөнхүү зорилгоор Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгогдсон хүн тухайн шалгах асуудлын хүрээнд хамаарах төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

4.Төрийн нууцыг хариуцаж байгаа төрийн төв, орон нутгийн болон бусад байгууллагын төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн тухайн байгууллагын дарга батална.

20 дугаар зүйл.Төрийн нууцыг шилжүүлэх, татан авах

1.Төрийн нууцыг дараахь үндэслэлээр шилжүүлж болно:

1/Монгол Улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн нууцыг бусад байгууллагатай хамтран ашиглаж тодорхой зорилго биелүүлэх;

2/энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр.

2.Төрийн нууцыг дараахь тохиолдолд төрийн төв байгууллага нь татан авна:

1/төрийн нууцыг хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс төрийн нууц задрах бодит нөхцөл байдал бий болсон;

2/тухайн байгууллага татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсаны улмаас төрийн нууцыг хариуцах үүрэггүй болсон;

3/нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн нууцыг тухайн байгууллага өөрийн хүчээр хамгаалах боломжгүй болсон.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл.Төрийн нууцыг ил болгох

1."Төрийн нууцыг ил болгох" гэж төрийн нууцыг Улсын Их Хурлын шийдвэрээр төрийн хамгаалалтаас гаргахыг хэлнэ.

2.Төрийн нууцыг дараахь үндэслэлээр ил болгоно:

1/нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцлах шаардлагагүй болсон;

2/нууцлах хугацаа дуусгавар болсон;

3/хуульд заасан бусад үндэслэл.

3.Төрийн нууцыг ил болгох асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

4.Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага гарсан онцгой тохиолдолд Тагнуулын төв газрын даргын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч уул асуудлыг шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, хувь хүний нууцыг төрийн нууцад хамааруулах

Монгол Улсын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор шаард-лагатай тохиолдолд төрийн бус байгууллага, хувь хүний нууцыг энэ хуульд заасан журмын дагуу төрийн нууцад хамааруулж болно. Ийнхүү хамааруулснаас учирч болох эд хөрөнгийн хохирлыг өмчлөгчтэй байгуулсан гэрээг үндэслэн төрөөс нөхөн олгоно.

23 дугаар зүйл. Төрийн нууц хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх Төрийн нууц хамгаалах үйл ажиллагааг улсын төвөөс санхүүжүүлнэ.

24 дүгээр зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Энэ хуулийн дор дурдсан зүйл, заалтыг зөрчсөн этгээдэд шүүгч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

1/6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн бол 500-2500 төгрөгөөр торгох;
2/9 дүгээр зүйл, 10 дугаар зүйлийн 2, 3, 11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн бол 1000-5000 төгрөгөөр торгох;

3/10 дугаар зүйлийн 1, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг зөрчсөн бол 5000- 10000 төгрөгөөр торгох.

4/төрийн нууцыг хувийн зорилгоор ашигласан бол 20000-50000 төгрөгөөр торгох.

25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ

1995.05.16

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь байгууллагын нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Байгууллагын нууцын тухай хууль тогтоомж

Байгууллагын нууцын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Байгууллага, байгууллагын нууцын тухай ойлголт

1. Байгууллага, байгууллагын нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно:
2/"байгууллагын нууц" гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

2. Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох

нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫГ ТОГТООХ, ХАМГААЛАХ

4 дүгээр зүйл. Байгууллагын нууцыг тогтоох

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т хамаарах нууцыг Улсын Их Хурал хуулиар тогтоон баталгаажуулна.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хамаарах нууцыг байгууллага өөрөө тогтооно.

3. Байгууллагын нууц нь эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд саад учруулахаар байж болохгүй.

5 дугаар зүйл. Байгууллагын нууцыг хамгаалах

1. Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө.

2. Байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу анилцсан, олж мэдсэн этгээд уул нууцыг чанд хадгалах үүрэгтэй.

3. Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцын нэг адил хамгаална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

6 дугаар зүйл. Нууцлахыг хориглох мэдээллийн хүрээ

Байгууллага дор дурдсан мэдээллийг нууцалж болохгүй:

1/тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;

2/тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөнтөхиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл;

3/гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.

7 дугаар зүйл. Байгууллагын нууцтай танилцах

1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, тэдгээрийн ажилтан нь хянан шалгах бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу байгууллагын нууцтай танилцана.

2. Байгууллагын нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.

3. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу хэрэгжүүлж байгаа хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчиж нууцалсан байгууллагын нууцыг ил болгох эрхтэй бөгөөд тухайн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалтай холбогдолтой

байгууллагын нууцад хамаарах зарим тодорхой мэдээллийг бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй тохиолдолд нийтэд мэдээлж болно.

8 дугаар зүйл. Шүүхэд гомдол гаргах

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээд хуулиар тогтоосон нууцыг нь бусдад задруулсан гэж үзвэл байгууллага энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

9 дүгээр зүйл. Хариуцлага

Байгууллагын нууцыг хариуцдаг эсхүл түүнтэй танилцсан этгээд уул нууцыг задруулсан бол хөдөлмөрийн гэрээ, тухайн байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээх бөгөөд хуулиар тогтоосон байгууллагын нууцыг задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000-50000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

10 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ

1995.04.21

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хувь хүний нууцын тухай ойлголт

"Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

3 дугаар зүйл.Хувь хүний нууцын тухай хууль тогтоомж

Хувь хүний нууцын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТӨРӨЛ, ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫГ ХАМГААЛАХ

4 дүгээр зүйл.Хувь хүний нууцын төрөл

1.Хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна:

- 1/захидал харилцааны нууц;
- 2/эрүүл мэндийн нууц;
- 3/хөрөнгийн нууц;
- 4/гэр бүлийн нууц;
- 5/хуулиар тогтоосон бусад нууц.

2.Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө,гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно:

1/захидал харилцааны нууцад захидал, цахилгаан,илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг;

2/эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг,нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;

3/хөрөнгийн нууцад зөвхөн эд хөрөнгө,оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг;

4/гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн,түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр,алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг.

3.Хувь хүний өөрийн архив,хадгаламж,тэмдэглэл,битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно.

5 дугаар зүйл.Хувь хүний нууцыг хамгаалах

1.Хувь хүн нууцаа өөрөө хамгаална.

2.Шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болно.

3.Хуулиар тусгайлан эрх олгогдсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хувь хүний нууцтай танилцана.

4.Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

6 дугаар зүйл.Хувь хүний нууцыг ил болгох

Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх

бүхий байгууллага /албан тушаалтан/-ын шийдвэрээр хувь хүний эрүүлмэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно.

7 дугаар зүйл.Шүүхэд гомдол гаргах

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан этгээд өөрийнх нь нууцыг бусдад задруулсан гэж үзвэл хувь хүн энэ тухай гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

8 дугаар зүйл.Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 20000- 50000 төгрөгөөр торгох захиргааны шийтгэл ногдуулна.

9 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

1995-05-27

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН АЛБА ХААГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ОНЦЛОГ

17 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлын онцлог

1.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

2/хамгаалуулагчийн тухай өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэвлэл,мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх, хувийн нууцынх нь талаар хэвлэн нийтлэх;

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

1995.03.27

1996.12.19

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

5 дугаар зүйл.Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам

15.Хяналт шалгалтын байгууллага өөрийн чиг үүргийн хүрээний асуудлаар иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу хяналт шалгалт явуулж болно.Хяналт шалгалтын байгууллага мэдээллийн нууцыг чандлан хамгаална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1995 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ

1995-11-14

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОНЦ БАЙДАЛ ЗАРЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

4 дүгээр зүйл.Онц байдал зарлах үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурдсан онцгой нөхцөл бий болсон үед онц байдал зарлаж болно:

1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учирлуулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул / газар хөдлөлт, хүчтэй салхи, ган, зуд, үёр, түймэр, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хордуулалт, хүн, малын гоц халдварт өвчин зэрэг тохиолдсон:/

2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй болсон.

7 дугаар зүйл.Онц байдал зарлах, түүний хугацааг сунгах, онц байдлыг цуцлах тухай шийдвэр хүчин төгөлдөр болох

2.Онц байдал зарлах, түүний хугацааг сунгах, онц байдлыг цуцлах тухай

шийдвэрийг түүнийг хэрэгжүүлэх байгуулагад нэн даруй хүргүүлж, олон түмний мэдээллийн хэрэгсэл, боломжтой бусад аргаар нийтэд шуурхай мэдээлж, албан ёсоор нийтэлнэ

16 дугаар зүйл.Онцгой арга хэмжээ

1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр онц байдал тогтоосон бол дор дурдсан онцгой арга хэмжээ тогтоож болно:

4/олшруулах болон дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтыг хязгаарлах буюу хориглох, шаардлагатай бол түр хураан авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

25 дугаар зүйл. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн онц байдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөх

Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Онц байдлын тухай хууль тогтоомжийг Монгол Улсын иргэний нэгэн адил дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГАДААД ХУДАЛДААНЫ АРБИТРЫН ТУХАЙ

1995-10-26

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар зүйл.Арбитрын хуралдаан явуулах хэлбэр, нууц хадгалах

1.Арбитрын хуралдааныг нээлттэй явуулна.

2.Хэргийн нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний болон талуудын худалдааны нууцтай холбогдолтой бол арбитр өөрийн санаачилгаар буюу талуудын хүсэлтээр хуралдааныг хаалттай явуулж болно. Энэ тохиолдолд шийдвэрийг ил сонсгоно.

3.Арбитрын хуралдааны үед илэрхий болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүн болон хуралдаанд оролцогчид хадгалах үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хууль хүчин төгөлдөр болох

57 дугаар зүйл Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хуулийг 1995 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр ажиллагаанд байгаа хэргийг хянан шийдвэрлэхэд энэ хуулийг буцааж хэрэглэхгүй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТАХИР ДУТУУ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

1995-12-19

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТАХИР ДУТУУ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

10 дугаар зүйл. Тахир дутуу хүний соёл, урлаг, биеийн тамирын арга хэмжээ

3.Тахир дутуу хүний сэтгэл санааг өөдрөг байлгах зорилгоор дор дурдсан арга хэмжээг төр зохион байгуулна:

1/тахир дутуу хүний ажил, амьдралын талаар төрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй сурталчлах;

2/хараагүй, дүлий, оюуны хомсдолтой хүнийг түүнд зориулсан хэвлэл, мэдээллийн материалаар хангах, телевизийн хөтөлбөр, зарим киног дохионы хэлний орчуулгатай гаргах;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ

1995-10-19

9 дүгээр зүйл. Санал асуулга бэлтгэн явуулах ажлын ил тод байдал

- 1.Санал асуулга бэлтгэн явуулах ажил ил тод байна.
- 2.Төрийн байгууллагын харьяалал бүхий хэвлэл, мэдээллийн байгууллага санал асуулга бэлтгэн явуулах ажлын явц, санал асуулгын дүнг олон нийтэд шуурхай, үнэн зөв

мэдээлэх үүрэгтэй.

17 дугаар зүйл.Санал асуулгын талаар явуулах ухуулга,сурталчилгаа

Санал асуулгаар тавигдаж байгаа асуудлын талаар ард нийтэд таниулах, мэдээллээр хангах асуудлыгтөр хариуцна.

Нам, олон нийтийн байгууллага өөрсдийн хүч хөрөнгөнд тулгуурлан сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр ухуулга, сур- талчилгаа явуулж болно.

2.Аливаа ухуулга, сурталчилгааг санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын шийдвэр хүчин төгөлдөрболсон өдрөөс хойш эхэлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө зогсооно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ

1995-11-16

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглах, хамгаалах, төр болон үйлчлэгч байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/"шугам" гэж мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авах зорилгоор байгуулсан аливаа дамжуулагч орчин /утас, орон, зай зэрэг/, тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч, сувагчлал, багана, цамхаг болон бусад зүйлсийн цогцолбор;

2/"сүлжээ" гэж хоёр буюу түүнээс дээш хэрэглэгчдийн хооронд мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авахад хэрэглэгдэх холбооны шугам, шуудангийн илгээмжийг хүлээн авах, ялган боловсруулах, тээвэрлэх, гардуулахад зориулагдсан техник хэрэгслийн иж бүрдэл;

4/"үйлчилгээ, үйлчлэгч" гэж харилцаа холбооны сүлжээг ашиглан хэрэглэгчдийн хэрэгцээг хангах үйл ажиллагаа; харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

4 дүгээр зүйл.Харилцаа, холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх, хөрөнгө оруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

2/харилцаа холбооны салбарт шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

3/радио долгионы зурвасыг төлөвлөх, долгион ашиглах эрхийн зөвшөөрөл олгож хяналт тавих;

4/харилцаа холбооны сүлжээ, тоног төхөөрөмж, үйлчилгээний стандартыг боловсруулж батлуулах, ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хэрэгжилтэд хяналт тавих;

7/харилцаа холбооны үйлчилгээг найдвартай, шуурхай, чанартай байлгах, захидал харилцааны нууцын хамгаалалтад хяналт тавих.

5 дугаар зүйл. Зохицуулах зөвлөл

1. Харилцаа холбооны салбарт өмчийн бүх төрөл, хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын үр ашигтай, шударга өрсөлдөх боломж бүрдүүлэх, тэдгээрийн харилцан ажиллах нөхцөл, болзол, журмыг боловсруулах, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй орон тооны бус Зохицуулах зөвлөл ажиллана.

2. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн нь харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ үйлдвэрлэл эрхэлдэг өмчийн бүх төрөл, хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлтэй байна.

3. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн сайд томилж, дүрмийг Засгийн газар батална.

6 дугаар зүйл. Зохицуулах зөвлөлийн бүрэн эрх

Зохицуулах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх төрийн бодлогын талаар саналаа боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

2/төрийн захиргааны төв байгууллагаас харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал, зөвлөмж гаргах;

3/харилцаа холбооны суурь сүлжээнд холбогдох өмчийн бүх төрөл, хэлбэрийн сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулахад тавих техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох;

4/хоорондоо холбогдох сүлжээ бүхий үйлчлэгчдийн харилцан холболт хийх болон орлого хуваарилах зарчим, гэрээний ерөнхий нөхцөл, журмыг тогтоож зохицуулах;

5/харилцаа холбооны үйлчилгээний тарифыг тодорхойлох үнэлгээний аргачлал тогтоох.

7 дугаар зүйл. Бүх шатны Засаг даргын бүрэн эрх

1. Бүх шатны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нутаг дэвсгэрийн холбооны үйлчилгээг сайжруулж, хүн амд ойртуулах бодлогыг боловсруулж холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2. Радио телевизийн орон нутгийн сүлжээ байгуулж, ашиглаж болно.

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

1. Харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ дараахь тохиолдолд олгоно:

1/харилцаа, холбооны суурь сүлжээг байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхлэх;

2/дотоодын хэрэглээний сүлжээгээр нийтийн үйлчилгээ эрхлэх;

3/радио долгион ашиглах;

4/холбоо, мэдээллийн техник, электрон хэрэгсэл үйлдвэрлэх;

2. Тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжид заасан шаардлага хангасан дараахь этгээдэд олгоно:

1/Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн;

2/Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж.

3. Гадаадын хуулийн этгээдэд харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын зөвшөөрлийг үндэслэн олгоно.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад төрлийн харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх бол аж ахуйн нэгж, байгууллага, иргэн энэ тухайгаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх олгогдсон байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

9 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл гаргах

1.Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг сонирхогч этгээд төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

2.Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргана:

1/санхүү-эдийн засаг, техникийн болон мэргэжлийн боловсон хүчний чадавхи;

2/үйл ажиллагааны үндсэн чиглэл, туршлага;

3/хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар:

а/үйлчилгээний хамрах хүрээ, байршил;

б/нэвтрүүлэх технологи;

в/үйлчилгээний тарифын санал;

г/тусгай зөвшөөрлийн үнийн санал.

10 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн хугацаа

1.Тусгай зөвшөөрлийн хугацааг 20 хүртэл жилээр олгоно.

2.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх асуудлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг цуцлах

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь зөрчил гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллага нь уг зөвшөөрлийг дангаараа цуцлах эрхтэй:

1/харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглах, хамгаалах талаар хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

2/тусгай зөвшөөрөлд зааснаас өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн бол түүний хүсэлтээр уг зөвшөөрлийг хугацаанаас өмнө цуцалж болно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг цуцалснаас учирсан хохирлыг уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага хариуцахгүй.

4.Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

17 дугаар зүйл.Радио телевизийн нэвтрүүлгийн сүлжээ

1.Радио болон телевизийн хөтөлбөрийг нэвтрүүлэх, хүлээн авах, дамжуулах тоног төхөөрөмж, техник хэрэгслээс радио телевизийн нэвтрүүлгийн сүлжээ бүрдэнэ.

2.Орон даяар хэрэглэгчдэд радио, телевизийн хөтөлбөрийг хүргэж байгаа тоног төхөөрөмж, шугамын иж бүрдэл нь радио, телевизийн нэвтрүүлгийн суурь сүлжээ мөн.

3.Монгол Улсын радио, телевизийн нэвтрүүлгийн сүлжээг радио телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэх байгууллагын захиалга, хуваарийн дагуу ажиллуулна.

21 дүгээр зүйл.Холбооны сүлжээг дайчлан ажиллуулах

Монгол Улсад онц болон дайны байдал зарласан тохиолдолд харилцаа холбооны сүлжээг хууль тогтоомжид зааснаар дайчлан ажиллуулна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛЧЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ**

22 дугаар зүйл. Үйлчлэгч, хэрэглэгчийн харилцан хүлээх үүрэг, хариуцлага

Үйлчлэгч, хэрэглэгчийн харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг Иргэний хуульд заасны дагуу гэрээгээр тогтооно.

23 дугаар зүйл. Үйлчлэгчийн эрх, үүрэг

1. Үйлчлэгч нь гэрээнд заасан эрхээс гадна дараахь эрхтэй:

1/харилцаа холбооны үйлчилгээний тарифыг Зохицуулах зөвлөлөөс гаргасан үнэлгээний аргачлалын дагуу тогтоох;

2/хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол үйлчилгээг зогсоож, гэрээг цуцлах.

2. Үйлчлэгч нь гэрээнд заасан үүргээс гадна дараахь үүрэгтэй:

1/харилцаа, холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрлийн хүрээнд

хэрэглэгчдэд ямар нэгэн ялгаваргүйгээр найдвартай шуурхай үйлчлэх;

2/харилцаа холбооны ашиглалт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн стандарт, техник, технологийн нөхцөл, горимыг дагаж мөрдөх;

3/харилцаа холбооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөх, үйлчилгээний зориулалтыг өөрчлөх, түр зогсоох тухай хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэх;

4/харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа бүх төрлийн мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах;

5/байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед холбооны сүлжээг хууль тогтоомжийн дагуу бусдад саадгүй хэрэглүүлэх;

6/байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоноос бусад үед холбооны үйлчилгээг зогсоохгүй байх.

3. Үйлчлэгч байгууллагын ажиллагсад нь төрийн хамгаалалттай аж ахуйн нэгж, байгууллагад байгаа өөрийн мэдлийн холбооны шугам, сүлжээнд засвар, үйлчилгээ хийх үедээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч ажиллана.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

СОЁЛЫН ТУХАЙ

1996-04-11

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дор дурдсан нэр томьёог дараахь утгаар ойлгоно:

1/"соёлын үйл ажиллагаа" гэдэгт соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой дараахь үйл ажиллагаа хамаарна:

д/олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах;

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
СОЁЛЫН УДИРДЛАГА , ЗОХИЦУУЛАЛТ**

13 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

З/олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр соёлын үйл ажиллагаа явуулахад оролцох;

14/ном, хэвлэл, кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

**ТАВДУГААР БҮЛЭГ
СОЁЛЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

19 дүгээр зүйл.Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт

3.Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

1996-05-07

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХҮҮХДИЙН ЭРХ, ЖУРАМТ ҮҮРЭГ**

6 дугаар зүйл.Хүүхдийн хөгжих эрх

5.Хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, мэдээлэл хайх эрхтэй.Хүүхдэд гэмт хэрэг, садар самуун, хүчирхийллийг сурталчлах, түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд өөрөө хүсээгүй бол хүүхдийг сурталчилгаанд ашиглахыг хориглоно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ТӨР, ОЛОН ТҮМНИЙ ОРОЛЦОО
13 дугаар зүйл.**Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хүүхдийн эрхийг хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:
6/хүүхдийн хөгжилд хохирол учруулах үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх, хүмүүжил, ёс суртахуунд нь сөрөг нөлөө үзүүлэх мэдээлэл тараах, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах зэрэг үйл ажиллагаа явуулахгүй байх;

/Энэ зүйлийг 2000 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн/.

МОНГОЛ УЛСЫН АВИЛГАЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ

1996-04-05

ХОЁРДУГААР БҮЛЭГ АВИЛГАЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

11 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн нууц

- 1.Хөрөнгө, орлогын мэдүүлэг хувь хүний нууцад хамаарна.
- 2.Хөрөнгө, орлогын мэдүүлгийн нууцыг хамгаалах, түүнийг ил болгох асуудлыг Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ

1996-05-27

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ӨМЧИЙН ЗҮЙЛС

6 дугаар зүйл.Хувьчлах хөрөнгийн талаар мэдээлэл хүргэх

- 1.Хувьчлагдах төрийн өмчит хуулийн этгээд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа, ногдол хувьтай холбогдох мэдээллийг Төрийн өмчийн хороо хувьчлах үйл ажиллагаа эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө төр, засгийн газрын албан ёсны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сонордуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

83 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийн зургаадугаар бүлгийг 1996 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс, бусад бүлгийг 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

1996-08-27

ЗУРГАДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ӨМНӨХ УХУУЛГА СУРТАЛЧИЛГАА, НЭР ДЭВШИГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТАЛГАА

23 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа, уулзалт

1. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн өмнөх сурталчилгаа явуулахдаа Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 21 дүгээр зүйлийн 1,2, 5,6 дахь хэсгийн заалтыг баримтална.

2. Орон нутгийн радио, телевизээр сонгуулийн ухуулга, сурталчилгаа үнэ төлбөргүй явуулах хугацаа, боломж нь нам, эвсэл бүрт, түүнчлэн сонгуульд өрсөлдөгч бие даан нэр дэвшигчдэд харилцан адил байна.

3. Сонгуулийн хорооноос тогтоож олгосон хугацаанаас бусад цагт нам, эвсэл, нэр дэвшигч орон нутгийн радио, телевизээр сурталчилгаа явуулбал үнэ хөлсийг төлнө.

25 дугаар зүйл. Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нам, эвслийн нэр дэвшигч нам, эвслийнхээ, бие даан нэр дэвшигч өөрийн хөтөлбөрийг тайлбарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга, сурталчилгаа хийх, аймаг, нийслэл, сум, дүүргийнхээ холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ

1996-09-03

ЗУРГАДУГААР БҮЛЭГ МОНГОЛБАНКНААС БУСАДТАЙ ХАРИЛЦАХ

34 дүгээр зүйл. Монголбанкны мэдээлэл

4. Монголбанк хууль тогтоомжийн дагуу статистикийн мэдээлэл, тайланг хэвлэлд нийтлүүлж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад заалт

43 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 10 дугаар сарын 1- ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ

1996-11-15

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

8 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын ажилтан

11. Хорих ангийн албан хаагч дараахь эрх эдэлнэ:

3/оргосон хоригдлыг эрэн сурвалжлах, мөрдөн хөөх, баривчлах үед зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллагын

тээврийн хэрэгслийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түр дайчлах, холбоо, мэдээллийн хэрэгслээр дараалал харгалзахгүй үйлчлүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

1997-02-06

ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА

10 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа

6. Улсын Их Хурлын гишүүний харилцуур утас болон бусад холбооны хэрэгсэл төрийн хамгаалалтад байх бөгөөд бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

1997-02-06

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

4 дүгээр зүйл. Хуралдааны нийтлэг журам

8. Хуралдаанд иргэд, дотоод, гадаадын зочид, төлөөлөгчид, хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтан зохих журмын дагуу байлцаж болно. Энэ журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно.

9. Улсын Их Хурлын хуралдаан нээлттэй байна. Улсын Их Хурлын хуралдааны явц, шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

10. Хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг хаалттай явуулж болно. Асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэхэд дараахь журмыг баримтална:

1/улсын нууцын жагсаалтад хамаарах асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Уг жагсаалтад ороогүй асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно;

3/хаалттай хуралдаанд албан ёсоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд бичлэг хийх, дуу хураагч, гар утас авч орох, утсаар ярихыг хориглоно;

5/хаалттай хуралдааны талаар зөвхөн нууцын дэвтэрт тэмдэглэл хийнэ;

6/хаалттай хуралдааны талаар энэ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу нийтэд мэдээлж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭХ

45 дугаар зүйл. Улсын Их Хурлын шийдвэрийг нийтлэх, мэдээлэх

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг "Төрийн мэдээлэл" эмхтгэлд албан ёсоор нийтэлнэ.

/Энэ хэсгийг 1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ "Төрийн мэдээлэл" эмхтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд ийнхүү дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

/Энэ хэсгийг 1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.Улсын Их Хурлын чуулганы явцын тухай олон нийтэд сонордуулах албан ёсны мэдээллийг зөвхөн Тамгын газар хариуцан нийтлүүлнэ.

4.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийг Улсын Их Хурлын номын сан, Улсын төв болон аймаг, нийслэл дэх төв буюу төвлөрсөн номын санд тавина.

46 дугаар зүйл."Төрийн мэдээлэл" эмхтгэл

1."Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаарх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам ,агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ. Энэхүү эмхтгэлийг Улсын Их Хурлын Тамгын газар долоо хоног тутам гаргана.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

СТАТИСТИКИЙН ТУХАЙ

1997-06-05

ГУРАВДУГААР БҮЛЭГ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

10 дугаар зүйл. Статистикийн мэдээллийг хэрэглэгчийн эрх, үүрэг

Статистикийн мэдээллийг хэрэглэгч дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2/ албан ёсны статистикийн мэдээллийг ашиглах, хэвлэн нийтлэхдээ уг мэдээллийг гаргасан байгууллагын нэрийг заавал заах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮРЭН ЭРХ

12 дугаар зүйл. Үндэсний статистикийн газар, түүний бүрэн эрх

2.Үндэсний статистикийн газар нь мэдээллээр төлбөртэй үйлчилгээ явуулах, статистикийн эмхтгэл, танилцуулга, бусад баримт бичгийг хэвлэн нийтлэх чиг үүрэг бүхий нэгжтэй байж болно. Тухайн нэгжийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ БҮРЭН ЭРХ

18 дугаар зүйл. Яам,төрийн бусад албан газар, бүх шатны Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи нийтлэг бүрэн эрх
Яам,төрийн бусад албан газар, бүх шатны Засаг даргын статистикийн мэдээллийн талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

З/мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

22 дугаар зүйл. Статистикийн мэдээллийг хууль бусаар ашиглах, мэдээллийн нууцыг задруулахыг хориглох

1. Албан ёсны статистикийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын ажилтан албан ёсоор мэдээлэх түвшинд хүрээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нууцад хамаарах мэдээллийг нийтэд задруулахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ Х У У Л Ъ

1997-02-06

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

13 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэн эрх, эрхлэх асуудал

2. Байнгын хороо дараахь эрхлэх асуудлын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:
6/ Хууль зүйн байнгны хороо:
- хэвлэл, мэдээллийн эрх чөлөө;
- патент, зохиогчийн эрх, худалдааны тэмдгийн асуудал;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АУДИТЫН ТУХАЙ

1997-05-1

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧ, АУДИТОР
18 дугаар зүйл.** Хэвлэлд мэдээлэх

Мэргэжлийн зөвлөл бүртгэсэн болон бүртгэлээс хассан мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын тухай мэдээллийг төрийн хэвлэлд нийтлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Аудитын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

40 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1997 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

1997-12-05

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

11 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг

11.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн тухай мэдээлэл хийхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл, хор холбогдлыг олон түмэнд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно.

11.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр яаралтай нийтэлж нэвтрүүлнэ.

11.3. Төрийн өмчийнхөөс бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр яаралтай мэдээлэл нийтэлж нэвтрүүлсний төлбөрийг тухайн байгууллага төлнө.

11.4. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.

11.5. Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

**ТАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

23 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

23.3. Энэ хуулийн 11.3, 11.4-т заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох, түүнчлэн уг зөрчлийг удаа дараа давтал байгууллагын үйл ажиллагааг зогсоох шийтгэлийг шүүгч ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ

1997-10-31

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

12 дугаар зүйл. Хориглох үйл ажиллагаа

12.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.1.1. нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг геодези, зураг зүйн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хэвлэн нийтлэх, хувилах, олшруулах, сурталчилгаанд ашиглах, бусдад дамжуулах;

12.1.4. зохих хууль тогтоомжид заасан журмыг зөрчин байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хийсэн зураг зүйн бүтээлийг хуулбарлах, олшруулах, хэвлэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

15 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1997 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

1997-11.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ**

13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээлэл дамжуулах

13.4. Байгалийн гамшгийн тухай мэдээллийг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн ялгаа харгалзахгүйгээр эхний ээлжинд шуурхай дамжуулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ

1997-12-19

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ БҮРЭН ЭРХ,
ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН САНХҮҮЖИЛТ**

13 дугаар зүйл.Гүйцэтгэх байгууллага, тэдгээрийн ажилтны бүрэн эрх
13.2.2.шаардлагатай бол байгууллага, иргэдийн байр, орон сууц, тээвэр, холбоо, мэдээллийн хэрэгслийг зохих хөлстэйгээр ашиглах;

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДАМПУУРЛЫН ТУХАЙ

1997-11-20

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

харуцагчийг татан буулгах

33 дугаар зүйл.Хариуцагчийг татан буулгах

33.2.Хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 хоногийн дотор шүүх энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

САДАР САМУУН Явдалтай ТЭМЦЭХ ТУХАЙ

1998-01-22

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "садар самууныг сурталчлах" гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг;

3.1.2. "садар самуун явдал" гэж биеэ үнэлж явалдах, түүнд бусдыг уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг;

3.1.3. "эротик" гэж гоо сайхны таашаал төрүүлэх зорилгоор хүний нүцгэн биеийг урлаг, уран сайхны хэлбэрээр үзүүлэхийг.

5 дугаар зүйл. Садар самууныг сурталчлахыг хориглох

5.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.

5.2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

5.3. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

6 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

6.1. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон эрүүл мэнд, хэвлэл, мэдээлэл, гэгээрлийн байгууллагууд садар самуун явдлын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах, бэлэгсийн халдварт болон дархлалын олдмол хомсдол өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа явуулах үүрэгтэй.

Эротикийн сурталчилгаа, үйлчилгээнд тавих шаардлага

7 дугаар зүйл. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам

7.1. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг аймаг, нийслэлийн Засаг даргаас тогтоосон тусгай цэгт худалдана.

7.2. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдахад дараахь зүйлийг хориглоно:

7.2.1. албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс, барааны зах, худалдаа, үзвэр үйлчилгээний газар худалдах;

7.2.2. гар дээрээс худалдах;

7.2.3. 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах.

8 дугаар зүйл. Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйл

8.1. Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхэд дараахь зүйлийг хориглоно:

8.1.1.гэгээрлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас тусгайлан зөвшөөрснөөс бусад газарт энэ төрлийн кино, дүрс бичлэгийг үзүүлэх;

8.1.2. телевизийн нийтийн сувгаар дамжуулах;

8.1.3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэх.

9 дүгээр зүйл. Эротикийн сурталчилгаанд тавих хяналт

9.1.Эротик чиглэлийн хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэгт тавих хяналтыг эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, гэгээрлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх зөвлөл /цаашид "Зөвлөл" гэнэ/ хэрэгжүүлнэ. 9.2.Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

9.3.Эротик хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэгийг зөвхөн Зөвлөлөөр хянуулсны дараа хэвлэн нийтлэх, нийтэд үзүүлэхийг зөвшөөрнө.

11 дүгээр зүйл. Татварын хувь, хэмжээ

11.1.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдсан буюу төлбөртэй ашиглуулсан, эротик тоглолт явуулсан үйлчилгээний орлогод Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 -т заасан хувь, хэмжээгээр татвар ногдуулна.

13 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

13.1.Энэ хуулийн 5.1, 5.2-т заасан зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

13.2.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

13.2.3.энэ хуулийн 5.1-ийг зөрчсөн бол садар самууныг сурталчилж олсон орлогыг хурааж, гэм буруутай албан тушаалтныг 40000-60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-150000 хүртэл төгрөгөөр торгох, энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох;

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

14 дугаар зүйл.Хуулийн заалтыг дагаж мөрдөх журмын тухай

14.1Энэ хуулийн 6.2-т заасныг 1998 оны 7 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АРХИВЫН ТУХАЙ

1998-01-02

25 дугаар зүйл. Архивын баримтын ашиглалт

25.3. Архивын баримтыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр архив өөрөө санаачлан сурталчилж болно.

25.7. Архивт байгаа хуулиар хамгаалсан төрийн болон бусад нууцад холбогдох баримтыг үүссэн цагаас нь хойш 30 жил өнгөрсний дараа нийтэд ашиглахыг зөвшөөрнө.

25.8. Үндэсний аюулгүй байдал, улсын онц чухал эрх, ашиг сонирхолд хамаарах баримтыг 50 жил, иргэдийн хувийн амьдрал, эд хөрөнгийн байдалд холбогдолтой баримт бичгийг 70 жил өнгөрсний дараа нийтэд ашиглуулна.

25.9. Төрийн архивын баримтыг хувь хүн, байгууллага хэвлэн нийтлэх тохиолдолд архивт хадгалагдаж байгаа эх хувьтай нь тулгаж хянасан, энэ талаар төрийн архиваас зохих зөвшөөрөл авсан байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ

1998-01-02

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах

18 дугаар зүйл. Хэлмэгдэгчийг цагаатгасан тухай олон түмэнд мэдээлэх

18.1. Энэ хуулийн дагуу цагаатгагдсан хэлмэгдэгчийн овог, нэр, товч намтар, хэрхэн хэлмэгдүүлсэн болон цагаатгасан тухай төрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон түмэнд үнэ төлбөргүй мэдээлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДАЙН БҮХИЙ БАЙДЛЫН ТУХАЙ

1998-01-08

5 дугаар зүйл. Дайн бүхий байдал зарлах

5.5. Дайн бүхий байдал зарласан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нэн даруй зарлана.

7 дугаар зүйл. Дайн бүхий байдлыг цуцлах

7.3. Дайн бүхий байдлыг цуцалсан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нэн даруй зарлана.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЭМИЙН ТУХАЙ

1998-05-07

17 дугаар зүйл. Эмийн талаархи мэдээлэл, сурталчилгаа

17.1.Эмийн тухай мэдээлэл нь үнэн, зөв, бодитой бөгөөд үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчээс хараат бус байна.

17.2.Эмийн тухай бодит мэдээллээр эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг хангах ажлыг төрийн захиргааны холбогдох төв байгууллагын зөвшөөрснөөр мэргэжлийн байгууллага зохион байгуулж хэрэгжүүлнэ.

17.3.Эмийн сурталчилгаанд дараахь зүйлийг хориглоно:

17.3.1.эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг импортлох, борлуулах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

17.3.2.жороор олгохоор заагдсан эмийг борлуулах зорилгоор сурталчлах;

17.3.3.мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

17.3.4.тухайн эмийн чанарыг өрөөсгөлөөр сурталчлах;

17.3.5.зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэхээр заагдсан эмийг эмийн санд борлуулахаар сурталчлах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох тухай

Энэ хуулийг 1998 оны 7 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ

1998-05-15

5 дугаар зүйл. Дайны байдал зарлах

5.4. Дайны байдал зарласан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг дагаж мөрдөхөөс нь 6-аас илүүгүй цагийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

6 дугаар зүйл. Дайны байдлыг цуцлах

6.3. Дайны байдлыг цуцалсан тухай Улсын Их Хурлын шийдвэрийг нэн даруй олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ

1998-05-15

34 дүгээр зүйл. Дайчилгааны арга хэмжээний нууцлалт

34.1.Цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр нь төрийн нууц мөн.
34.3.Зарлан мэдээлэхээс бусад цэргийн дайчилгаатай холбогдсон мэдээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах, сурталчлахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХҮНСНИЙ ТУХАЙ

1999

6 дугаар зүйл. Хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих дотоодын болон олон нийтийн хяналт

16.2.Иргэн, төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг төрийн захиргааны болон хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийг сэрэмжлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

1999-07-08

12 дугаар зүйл. Тагнуулын ерөнхий газрын эрх

12.1.Тагнуулын ерөнхий газар дараахь эрх эдэлнэ:

12.1.1.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд нууцаар ажиглах, үзлэг хийх, шуудан харилцаа хянах, харилцаа холбооны болон мэдээллийн бусад сүлжээнд нэвтрэх,

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ

1999-05-28

22 дугаар зүйл. Гал түймрийн аюулгүй байдлын талаархи мэдээ мэдээлэл

22.1.Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэхтэй холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараалал үл харгалзан төлбөртэйгээр нийтэлж нэвтрүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

28 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

28.1 Энэ хуулийг 1999 оны 7 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ

1999-06-04

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1 Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

3.1.4."үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт" гэж радио давтамжийн нийт зурвасыг радио холбооны үйлчилгээний төрөлд хуваасан хуваарилалтыг.

4 дүгээр зүйл. Радио долгионы өмчлөл

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч мөн.

4.1.1 Төр нь радио долгион өмчлөгчийн хувьд энэ хуульд заасан нөхцөл, болзолтойгоор радио давтамж, радио давтамжийн зурвасыг ашиглах эрхийг бусад этгээдэд олгоно.

5 дугаар зүйл. Радио долгионы талаар төрийн байгууллагын бүрэн эрх

5.1.Засгийн газар нь радио долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.2.радио давтамжийн хуваарилалтыг төрийн нууцад хамруулах, нууцлалын зэрэглэлийг тогтоох асуудлыг боловсруулах.

5.2. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1.радио давтамжийн зурвас ашиглалтын талаархи төрийн бодлого боловсруулах;

5.2.2. хил залгаа улстай радио долгионы асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын цахилгаан холбооны байгууллагаас тогтоосон журмын дагуу зохицуулах;

5.2.3.радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэл гаргах, радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, хуваарилах болон радио

давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам батлах ;

5.2.4.радио давтамж зохицуулалт, хяналтын албаны зардал, техник хэрэгслэлээр хангах санхүүжилтийн хэмжээг тогтоож батлах;

5.2.5.олон улсын радиогийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Радио давтамж ашиглах

6 дугаар зүйл. Радио давтамжийн зурвасын ангилал

6.1.Радио давтамжийн зурвасыг ашиглаж буй зориулалтаар нь дараахь байдлаар ангилна:

6.1.1. тусгай хэрэглээний

6.1.2. нийтийн хэрэглээний.

6.2. Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг тусгай хэрэглээний гэнэ.

6.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэгцээнд зориулж хуваарилсан радио давтамжийн зурвасыг нийтийн хэрэглээний гэнэ.

7 дугаар зүйл. Радио давтамжийн зурвас эзэмших эрх бүхий этгээд

7.1.Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, иргэн энэ хуулийн дагуу радио давтамж зохицуулалт, хяналтын албанаас тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авч, бүртгүүлж ашиглана.

7.2.Тусгай хэрэглээний радио давтамжийн зурвасыг радио давтамж зохицуулалт, хяналтын албанд бүртгүүлж ашиглана.

7.3.Монгол Улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар нь Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасыг энэ хуулийн 7.1-д заасны дагуу ашиглана.

7.4.Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах байгууллага нь нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвас ашиглах бол энэ хуулийн 7.1-д заасны дагуу ашиглана

8 дугаар зүйл. Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглох

8.1.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиггүй этгээд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл

9.1.Төрийн эрх бүхий байгууллагаас радио холбоо зохион байгуулах, түүнийг ашиглан үйлчилгээ эрхлэх, нийтийн үйлчилгээний зориулалтаар радио төхөөрөмж ажиллуулахын тулд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрх олгосон баримт бичгийг тусгай зөвшөөрөл гэнэ.

9.2.Тусгай зөвшөөрөлд радио төхөөрөмжийн байршил, хамрах нутаг дэвсгэр, ашиглах радио давтамж, хүчин чадал, үйл ажиллагаа эхлэх дуусах хугацаа, ашиглалтын зориулалт зэргийг заана

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах

10.1.Тусгай зөвшөөрөл авах өргөдөлд Харилцаа холбооны тухай хуулийн 9.2-т заасан баримт бичгээс гадна дараахь баримтыг хавсаргана:

10.1.1. гэрчилгээний хуулбар;

10.1.2.радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, газар зүйн байршил, хамрах хүрээ, ашиглах радио давтамжийн зурвас, радио давтамж, технологи;

10.1.3.радио төхөөрөмжийг баталгаажуулж эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг;

10.1.4. аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөл

10.2.Тусгай зөвшөөрөл авах өргөдөлд өргөдөл гаргагчийн нэр, харилцах хаяг, утас ба факсны дугаар, шийдвэр гаргах эрх бүхий хүний албан тушаал, нэрийг тусгана.

11 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

11.1.Радио давтамж зохицуулалт, хяналтын алба тусгай зөвшөөрөл авах өргөдлийг хүлээн авмагц өргөдөл болон түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 10.1-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана.

11.2. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл авах өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

11.2.1. радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох;

11.2.2. тухайн радио давтамж нь тусгай хэрэглээний ангилалд орсон, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглагдаж байгаа, радио давтамжийн үйлчлэх хүрээтэй давхацсан, харилцан нөлөөлөл үүсгэх бол радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах.

11.3.Тухайн радио давтамжийг ашиглах асуудлыг олон улсын байгууллага зохицуулдаг бол уг радио давтамжийг олон улсын байгууллагаас санал авсны үндсэн дээр энэ хуулийн 11-д заасны дагуу ашиглана.

11.4.Ижил радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд

өргөдөл гаргасан тохиолдолд өрсөлдүүлэн шалгаруулах журмаар тусгай зөвшөөрөл олгож болно.

11.5.Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд нь түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлнө. Жилийн төлбөр төлөөгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохгүй.

12 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

12.1.Радио давтамж зохицуулалт, хяналтын алба өргөдөл гаргасан этгээд тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор тусгай зөвшөөрлийг 15 хүртэл жилийн хугацаатайгаар олгоно.

12.2.Тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь хугацаа сунгах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 ба түүнээс дээш хоногийн өмнө радио давтамж зохицуулалт, хяналтын албанд гаргана.

12.3. Хугацаа сунгуулах өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэхийг хянаж биелүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, нэгдсэн бүртгэлд тэмдэглэж эзэмшигчид нь буцааж олгоно.

14 дүгээр зүйл. Радио давтамж тусгай зөвшөөрөл,эрхийн бичиггүй ашиглах

14.1. Дараахь төрлийн радио төхөөрөмж ашиглахад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авахгүй:

14.1.1.бүх төрлийн зурагт радио, радио хүлээн авагч;

14.1.3.техникийн шаардлага хангасан гаралтын чадал нь 0.01 ваттаас ихгүй радио телефон утас, радио төхөөрөмж, гэр ахуйн электрон цахилгаан хэрэгсэл;

15 дугаар зүйл. Бүртгэл

15.1.Нэгдсэн бүртгэлд радио давтамжийн ангилал, зориулалт, ашиглагчийн нэр, хаяг, ашиглахыг зөвшөөрсөн радио давтамжийн зурвас, түүний өргөн, үйлчлэх хүрээ, газар зүйн байршил, ажиллуулах хугацаа, хүчин чадал, төлбөр төлөлтийн байдал зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр тусгана.

15.2.Нэгдсэн бүртгэлийг радио давтамж зохицуулалт, хяналтын алба хөтлөх бөгөөд түүнийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр танилцуулна.

16 дугаар зүйл. Үйлчилгээний төлбөр

16.1. Эрхийн бичиг авах, шилжүүлэх, тусгай зөвшөөрөл авах, тэдгээрийн хугацааг сунгах, бүртгүүлэх, харилцан нөлөөллийг шийдвэрлүүлэхээр өргөдөл гаргахад энэ хуулийн 5.2.3-т заасан журмын дагуу үйлчилгээний төлбөрийг өргөдөл гаргагч төлнө.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцлах

18.1.Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг Харилцаа холбооны тухай хуулийн 12-т заасан үндэслэл болон дараахь үндэслэлээр цуцална:

18.1.1.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь энэ хуульд заасны дагуу эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

18.1.2.тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь тусгай зөвшөөрөл, радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

18.1.3.тусгай хэрэглээний ангилалд ашиглаж байгаа радио давтамжийн зурвасыг ашигласан, санаатайгаар шуугиан үүсгэсэн буюу сонссон.

18.2.Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцлах үндэслэл байгааг тогтоовол радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь энэ тухай тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид мэдэгдэл өгнө. Уг мэдэгдэлд тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцлах болсон үндэслэлийг нотлох баримтын хамт заана.

18.3. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь мэдэгдэлд заасан үндэслэл байхгүй гэж үзвэл уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор өөрийн өргөдөл, гомдлыг нотлох баримтын хамтаар радио давтамж зохицуулалт, хяналтын албанд ирүүлж хянуулж болно.

18.4. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж хариу мэдэгдэнэ.

18.5. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн ирүүлсэн нотлох баримт бичгийг хүлээн зөвшөөрөх үндэсгүй гэж үзвэл радио давтамж зохицуулалт, хяналтын алба тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчид өөрийн дүгнэлтийн тухай мэдэгдэж, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг цуцална.

18.6. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь цуцалсан тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

18.7. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч шүүхэд гомдол гаргасан тохиодолд шүүхийн шийдвэр гартал тухайн радио давтамжид шинээр тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгож болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн эрх, үүрэг

19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчийн эрх, үүрэг

19.1.Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч нь дараахь эрхтэй:

19.1.1.стандарт, техникийн нөхцөлийг хангаж, баталгаажуулсан радио төхөөрөмжийг сонгон ашиглах;

19.1.4.хуульд өөрөөр заагаагүй бол радио давтамж ашиглах талаар сонирхсон мэдээллийг радио давтамж зохицуулалт, хяналтын албанаас авах.

19.2. Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигч дараахь үүрэг хүлээнэ:

19.2.1 энэ хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд радио төхөөрөмж импортлох, үйлдвэрлэх, худалдахыг сонирхогч этгээд радио давтамж зохицуулалт, хяналтын албатай радио давтамжийн талаар урьдчилан тохирох;

19.2.2.радио төхөөрөмжийг тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт заасан нөхцөл, хугацаа, зориулалтын дагуу ашиглах;

19.2.3.тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дараа жилийн төлбөрийг тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгосон тухайн ажлын өдрөөр тасалбар болгон жил бүр төлөх;

19.2.4.тусгай зөвшөөрөл, эрхийн бичигт заасан техникийн болон ашиглалтын нөхцөлд өөрчлөлт оруулах асуудлыг эрх олгосон байгууллагаар шийдвэрлүүлэх;

19.2.5.бусад радио холбоо, радио төхөөрөмжид харилцан нөлөөлөл үүсгэхгүй байх;

19.2.6.олон улсын хэмжээнд хэрэглэдэг аюулын дохио (SOS, MAYDAY зэрэг) бусад радио станцаас

ирсэн тохиолдолд энэ тухай холбогдох газарт даруй дамжуулах, мэдэгдэх;

19.2.7. тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн хугацаа дуусгавар болсон буюу тэдгээрийг цуцалсан тохиолдолд радио станцынхаа антенныг буулгах;

19.2.8.зөвхөн зөвшөөрөгдсөн радио давтамж, давтамжийн зурваст ажиллах, өөрийн эзэмшилд байгаа радио төхөөрөмжийн гаралтын чадал, давтамжийг тогтмол хянаж байх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл. Хяналт

20.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионы тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг радио давтамж зохицуулалт, хяналтын алба болон харилцаа холбооны улсын байцаагч хэрэгжүүлнэ.

20.2. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь харилцан нөлөөллийг арилгах, хууль тогтоомж зөрчсөн этгээдийг хайх, илрүүлэх үйл ажиллагааг радио давтамж эзэмшигчийн үйл ажиллагаанд саад хохирол учруулахгүйгээр зохион байгуулна.

20.3. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь олон улсын стандартын дагуу лабораторитой байж болно.

20.4. Төлбөрөө төлөөгүй радио давтамж ашиглагчид хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн дүнгийн 0,3 хүртэл хувьтай тэнцэх алданги ногдуулна.

20.5. Радио долгионы тухай хууль тогтоомжийг зөрчсөн дараахь тохиолдолд радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох эрхийг радио давтамж зохицуулалт, хяналтын алба эдэлнэ:

20.5.1. радио төхөөрөмж нь стандарт, чанарын үзүүлэлт, техникийн нөхцөлийн шаардлага хангаагүй;

20.5.2. тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг аваагүй, бүртгүүлээгүй;

20.5.3. төлбөр төлөөгүй, хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

20.5.4. бусад хэрэглэгчийн үйл ажиллагаанд харилцан нөлөөлөл үүсгэсэн, тэдний хэвийн ажиллагааг алдагдуулсан;

20.5.5. радио давтамж зохицуулалт, хяналтын албанд мэдэгдэлгүйгээр радио төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, давтамж болон ажиллах цагийн хуваарийг өөрчилсөн;

20.5.6. улсын байцаагчийн шаардлагыг биелүүлээгүй;

21 дүгээр зүйл Хуультоогомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

21.1 Радио долгионы тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд харилцаа холбооны улсын байцаагч буюу шүүгч дараахь захиргааны хариуцлага ногдуулна.

21.1.7. радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгох, бүртгэх журмыг зөрчсөн албан тушаалтныг 20000-50000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬ

200

21 дүгээр зүйл Улс төрийн баталгаа

21.2 Комиссын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, нийтлэх, шашин шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

23 дугаар зүйл Хууль зүйн баталгаа

Комиссын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

2000-01-28

9 дүгээр зүйл. Архидан согтуурахын эсрэг сурталчилгаа

9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.

9.2. Согтууруулах ундаа худалдах, худалдан борлуулах, хэрэглэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийхийг хориглоно.

10 дугаар зүйл. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааг нийтэд мэдээлэх

10.1. Эрх бүхий байгууллагын шалгалт, шинжилгээгээр хүний амь нас, эрүүл мэндэд хортой болох нь тогтоогдсон, стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай зарлан мэдэгдэнэ.

10.2. Стандартын шаардлага хангаагүй согтууруулах ундааны хор хөнөөлийн талаархи мэдээллийг бүх төрлийн хэвлэл мэдээллийн байгууллага саадгүй хүлээн авч, нийтэд түгээх үүрэгтэй.